

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20.... оны дугаар сарын ...ны өдөр

Улаанбаатар хот

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРХИЙН ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь хөгжлийн бэрхшээлтэй хүний ~~эрх~~, эрх чөлөөг **бүрэн эдлэх нөхцөлийг бүрдүүлэх**, нийгмийн харилцаанд **тэгш оролцоог хангах**, төрийн үйлчилгээ, бодлогын зохицуулалтыг **хүний эрхэд суурилсан** зарчмаар зохион байгуулахад төр, иргэн, хуулийн этгээдийн дэмжлэг, оролцоо, тэдний эрх, хүлээх үүрэг, хариуцлагатай холбогдох харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль тогтоомж

2.1.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Нийгмийн халамжийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Гэр бүлийн тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Боловсролын ерөнхий хууль, энэ хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол Монгол Улсын олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Энэ хууль Монгол Улсын иргэн болон Монгол Улсад хууль ёсоор байнга оршин суугаа гадаадын хүн, харьяалалгүй хүн, хуулийн этгээдэд нэгэн адил хамаарна.

4 дүгээр зүйл.Хуулийн нэр томьёоны тодорхойлолт

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.“хөгжлийн бэрхшээлтэй хүн” гэдэгт бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согог нь орчны болон хандлагын бусад саадтай нийлсний улмаас бусдын адил нийгмийн харилцаанд бүрэн, үр дүнтэй оролцох боломж нь хязгаарлагдсан хүнийг;

4.1.2.“хөгжлийн бэрхшээлээр нь ялгаварлан гадуурхах” гэж хөгжлийн бэрхшээлтэй хүн улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын харилцаанд хүний үндсэн эрх, эрх чөлөөг бусадтай адил тэгш эдлэх, нийгмийн баялгаас тэгш хүртэх, хөгжилд хувь нэмрээ оруулах, шаардлагатай тохируулгаар хангагдах, бие даан амьдрах боломжийг үгүйсгэх, хязгаарлах үйлдэл, эс үйлдэхүйг;

4.1.3.“туслах хэрэглэгдэхүүн” гэж хөгжлийн бэрхшээлтэй хүнд амьдралын өдөр тутмын үйлдлээ гүйцэтгэх, нийгмийн харилцаанд оролцоход дэмжлэг үзүүлэх, үйлдлийн чадварыг сайжруулах, эсвэл эрүүл мэндийг нь дордуулахгүйгээр тухайн түвшинд нь тогтоох зорилготой хэрэгсэл, тоног төхөөрөмж, эмнэлгийн хэрэгсэл, программ хангамж зэрэг;

4.1.4.“шаардлагатай тохируулга” гэж хөгжлийн бэрхшээлтэй хүн нийгмийн үйлчилгээ авах, хөдөлмөр эрхлэх, нийгмийн харилцаанд бие даан оролцохыг дэмжих зорилгоор тухайн хүнд

зориулан өөрчилсөн, эсхүл бүрдүүлсэн орчин, нөхцөл, хүний нөөц, үйлчилгээний төрөл, хэлбэр, хэрэгсэл, тоног төхөөрөмж, программ хангамж зэргийг;

4.1.6. “Олон нийтийн оролцоонд түшиглэн хөгжүүлэх үйлчилгээ” гэж хөгжлийн бэрхшээлтэй хүнд нийгмийн харилцаанд тэгш оролцох боломжийг бүрдүүлж, гэр бүл, хамт олны дунд эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн болон сэтгэлзүйн үйлчилгээг чанартай, хүртээмжтэй хүргэхийг;

4.1.7. “бие даан амьдрах” гэж хөгжлийн бэрхшээлтэй хүн шаардлагатай дэмжлэг, үйлчилгээний тусламжтайгаар амьдрах орчноо мэдээлэлтэйгээр өөрөө сонгох, шийдвэр гаргах, **тодорхой хариуцлага** хүлээхийг;

4.1.8. “Хувийн туслах” гэж хөгжлийн бэрхшээлтэй хүний амьдралын өдөр тутмын үйлдэлд болон бие даан амьдрахад түүний хэрэгцээнд нийцсэн үйлчилгээ үзүүлдэг хүнийг;

4.1.9. “хөтөч нохой” гэж хөгжлийн бэрхшээлтэй хүн тухайн орчинд зөв чиг баримжаатай, саадгүй, аюулгүй зорчиход нь туслах зорилгоор тусгайлан сургаж, бэлтгэсэн нохойг;

4.1.10. “Дохионы хэлний хэлмэрч, орчуулагч” гэж сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй хүнд ярианы болон бичгийн хэлнээс дохионы хэл рүү, дохионы хэлнээс ярианы болон бичгийн хэл рүү, дохионы хэлнээс дохионы хэл рүү хөрвүүлэн хэлмэрчилдэг хүнийг;

4.1.11. “нөхөн сэргээх үйлчилгээ” гэж хүний хөгжлийн бэрхшээлийн улмаас хүний алдагдсан чадвар, хязгаарлагдсан үйлдлийг тухайн хүний хөгжлийн бэрхшээлийн төрлөөс хамаарч алдагдсан чадварыг нь сэргээж болох түвшинд хүргэхээр үзүүлж буй эрүүл мэндийн сэргээн засах, боловсрол, хөдөлмөр, нийгэм, сэтгэлзүйн цогц үйлчилгээг;

5 дугаар зүйл. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, хамгаалахад баримтлах зарчим

5.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, хамгаалах бодлого, үйл ажиллагаанд дараах зарчмыг баримтална:

5.1.1. хөгжлийн бэрхшээлтэй хүнийг нийгмийн харилцаанд эрх тэгш оролцоход аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхахгүй, тусгаарлахгүй байх;

5.1.2. хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжих эрхийг хангах, сонголт хийх эрх, онцлог, хараат бус байдлыг хүндэтгэх;

5.1.3. хөгжлийн бэрхшээлтэй хүний сурч боловсрох, хөдөлмөрлөх зэрэг нийгмийн бүхий л харилцаанд оролцох эрхийг хангахад саадгүй, хүртээмжтэй орчин, нөхцөлийг бүрдүүлэх нь бүх нийтийн үүрэг байх;

5.1.4. төрийн бодлого, шийдвэрийг боловсруулах, хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих үйл ажиллагаанд хөгжлийн бэрхшээлтэй хүн, түүний эрх ашгийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг иргэний нийгмийн байгууллагын төлөөллийн оролцоог хангах;

ХОЁРДУГААР БҮЛЭГ

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ НИЙГМИЙН ХАРИЛЦААНД ТЭГШ ОРОЛЦОХ ЭРХ

6 дугаар зүйл.Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг үл ялгаварлан гадуурхах

6.1.Хөгжлийн бэрхшээлтэй эсэхээс үл хамааран хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байж, үндсэн эрх, эрх чөлөөгөө эдлэн, нийгмийн харилцаанд эрх тэгш оролцож, үндэсний баялгаас адил хүртэх эрхтэй.

6.2.Хүнийг хөгжлийн бэрхшээл болон эрүүл мэндийн байдлаар нь ялгаварлан гадуурхахыг хориглоно.

6.3.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах, сурч боловсрох, шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцох, улс төрийн эрхээ эдлэхэд хүн, хуулийн этгээдийн дараах шууд ба шууд бус үйлдэл, эс үйлдэхгүйг ялгаварлан гадуурхалт гэж үзнэ:

6.3.1.хөгжлийн бэрхшээлтэй хүн өөрийн онцлог хэрэгцээнд нийцсэн хэлбэрээр мэдээлэл авах, бусадтай харилцахад шаардлагатай орчин, нөхцөлийг бүрдүүлээгүй байх;

6.3.2.өмчийн хэлбэр харгалзахгүй бүх шатны боловсролын байгууллага хөгжлийн бэрхшээлээс нь шалтгаалан боловсролын үйлчилгээ үзүүлэхээс татгалзах, тэгш хамран суралцахад шаардагдах тохируулгат орчин, нөхцөлийг бүрдүүлэхгүй байх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нийгэм, хамт олны дунд бие хүн болж төлөвших, хөгжихийг хязгаарлах, үл хайхрах, дарамт, шахалт үзүүлэх;

6.3.3.хөгжлийн бэрхшээлтэй гэх шалтгааны улмаас зээл, санхүүгийн үйлчилгээ үзүүлэхээс татгалзах;

6.3.4.хөгжлийн бэрхшээлтэй хүний нөхөн үржихүйн эрхийг өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр хязгаарлах;

6.3.5.хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн асуудлаар төрийн бодлого, шийдвэрийг боловсруулах, хэрэгжүүлэх, хэрэгжилтэд нь хяналт тавих үйл ажиллагаанд хөгжлийн бэрхшээлтэй хүнийг оролцуулахаас татгалзах, зайлсхийх;

6.3.6.нийтийн барилга байгууламж, авто зам, замын байгууламжид хүрэх, түүнийг ашиглах, нийтийн тээврийн хэрэгслээр зорчих саадгүй, хүртээмжтэй орчин, нөхцөлийг бүрдүүлэхгүй байх;

6.3.7.хөгжлийн бэрхшээлтэй хүний сонгох, сонгогдох улс төрийн эрхээ хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлээгүй байх;

6.3.8.хөгжлийн бэрхшээлтэй хүнийг гутаан доромжлох, нэр төр, эрхэм чанарт халдах.

6.4.Хөгжлийн бэрхшээлтэй хүн хөдөлмөрлөх эрхээ эдлэхэд хүн, хуулийн этгээдийн дараах үйлдэл, эс үйлдэхгүйг ялгаварлан гадуурхалт гэж үзнэ:

6.4.1.ажлын байрны сонгон шалгаруулалтад оролцуулахаас татгалзах, сонгон шалгаруулалтад тэнцсэн хүнийг хөгжлийн бэрхшээлийн улмаас ажилд авахаас татгалзах, зайлсхийх;

6.4.2.хөдөлмөр эрхэлж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүний албан тушаал ахих, дэвших боломжийг хязгаарлах;

6.4.3.хуулийн этгээд ажилтныг хөгжлийн бэрхшээлээр нь ялгаварласан дүрэм, журам хэрэгжүүлэх, удирдлагын арга барилыг ашиглах;

6.4.4.гэр бүлийн гишүүн нь хөгжлийн бэрхшээлтэй гэсэн шалтгаанаар хүнийг ажилд авахаас татгалзах, чөлөөлөх, бусад хэлбэрээр ажил, хөдөлмөр эрхлэх эрхийг нь хязгаарлах;

6.4.5.хөгжлийн бэрхшээлтэй хүний онцлог хэрэгцээнд тохирсон, шаардлагатай тохируулга бүхий ажлын байрыг зохион байгуулахаас татгалзах, цалин хөлсийг ялгавартай тогтоох.

6.5.Дараах үйлдлийг гэр бүл, олон нийтийн орчин дахь ялгаварлан гадуурхалт гэж үзнэ:

6.5.1.хүнийг хөгжлийн бэрхшээлээр нь доромжлох, тохуурхах, хөгжлийн бэрхшээлтэй хүний эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, гэр бүлийн бусад гишүүнийг гадуурхах;

6.5.2.хөгжлийн бэрхшээлийн талаар олон нийтэд буруу, ташаа ойлголт төрүүлэхүйц мэдээлэл, зар сурталчилгаа явуулах, соёл урлагийн бүтээл хийх;

6.5.3.хүний сүсэг бишрэл, итгэл үнэмшилд тулгуурлан хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхэд халдсан аливаа зөвлөгөө өгөх;

6.5.4.эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, гэр бүлийн бусад гишүүн нь хөгжлийн бэрхшээлтэй хүнийг нийгмээс тусгаарлах, нуух, түүнийг нийгмийн харилцаанд оролцохыг аливаа хэлбэрээр хязгаарлах, хөгжүүлэх, чадавхжуулах үйлчилгээнд хамруулахаас татгалзах, зайлсхийх;

6.5.5.хөгжлийн бэрхшээлээс нь шалтгаалан хүнийг хуульд зааснаас бусад үндэслэлээр үр хүүхдээ асрамжиндаа авах эрхийг хязгаарлах;

6.5.6.хөгжлийн бэрхшээлтэй хүний үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх болон хуульд заасан бусад эрхийг хязгаарлах;

6.5.7.хөгжлийн бэрхшээлтэй гэсэн шалтгаанаар гэр бүлтэй болох, гэрлэх, хөрөнгө өвлөх эрхийг хязгаарлах.

6.6.Төрөөс хүнийг хөгжлийн бэрхшээлээс нь шалтгаалан бүх хэлбэрээр ялгаварлан гадуурхахыг хориглосон, ялгаварлан гадуурхалтад өртөхөөс хамгаалсан нийгэм, эдийн засаг, хууль зүйн олон талт арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

6.7.Хуулийн этгээд нь хөгжлийн бэрхшээлтэй хүнийг нийгмийн харилцаанд эрх тэгш, бүрэн, үр ашигтай оролцохыг баталгаажуулах зорилгоор шаардлагатай тохируулгаар хангах, саадгүй, хүртээмжтэй орчин нөхцөлийг бүрдүүлэх арга хэмжээг үе шаттайгаар авч хэрэгжүүлнэ.

6.8.Хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн харилцаанд тэгш оролцох эрхийг бодитой хангах, онцлог хэрэгцээнд нь тохируулах зорилгоор авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээг ялгаварлан гадуурхалт гэж үзэхгүй.

7 дугаар зүйл.Хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх

7.1.Хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

7.1.1.хуулийн этгээд нь ажилтан, албан хаагчдынхаа хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, түгээмэл загвар, шаардлагатай тохируулгын талаар сургалт, сурталчилгааг өөрийн зардлаар жилд 1-ээс доошгүй удаа зохион байгуулах;

7.1.2.хөгжлийн бэрхшээлийн талаар ойлголт, мэдлэгийг түгээх, энэ чиглэлээр төрөөс хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан таниулахад чиглэсэн нийтлэл, нэвтрүүлгийн хөтөлбөрийг олон нийтийн радио, телевиз үнэ төлбөргүй, бусад хэвлэл мэдээллийн байгууллага нийгмийн хариуцлагын хүрээнд нийтийн хүртээл болгох;

7.1.3.бүх шатны төрийн байгууллага хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжих, бие даан амьдрах боломжийг нэмэгдүүлэх, хүний эрхийг дээдэлсэн нийгмийн орчныг бүрдүүлэх, нийгэмд хөгжлийн бэрхшээлтэй хүний талаар эерэг ойлголт, мэдлэгийг төлөвшүүлэх арга хэмжээг зохион байгуулах, холбогдох зардлыг төсөвт тусган санхүүжүүлэх;

7.1.4.хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх болон төрөөс үзүүлэх үйлчилгээний талаарх мэдээ, мэдээллийг хөгжлийн бэрхшээлтэй хүн, түүний гэр бүлд хүргэхэд чиглэсэн сургалт, сурталчилгаа явуулах.

7.2.Энэ хуулийн 7.1.1-д заасан арга хэмжээг хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх ашгийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг хүн, хуулийн этгээдээр гэрээгээр гүйцэтгүүлж болно.

7.3.Энэ хуулийн 7.1.1-д заасан сургалтыг зохион байгуулах, сургагч багш бэлтгэх, төлбөрийн хэмжээг тогтоох журмыг хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

8 дугаар зүйл.Хөгжлийн бэрхшээлтэй хүний орчны хүртээмжийг сайжруулах

8.1.Барилга байгууламж, авто зам, замын байгууламж, нийтийн тээвэр, мэдээлэл, харилцаа холбоо, бүх төрлийн үйлчилгээ, мэдээллийн технологи нь хөгжлийн бэрхшээлтэй хүнд саадгүй, хүртээмжтэй түгээмэл загвартай байна.

Тайлбар: “түгээмэл загвар” гэж нэмэлт тохиргоо, тусгай загвар шаардахгүйгээр бүх хүн ашиглахад тохиромжтой, энгийн бүтээгдэхүүн, программ хангамж, орчин болон үйлчилгээний хэв маяг, архитекторын шийдлийг;

8.2.Энэ хуулийн 8.1-д заасан саадгүй, хүртээмжтэй орчныг бүрдүүлэх харилцааг тухайлсан хуулиар зохицуулна.

8.3.Хөгжлийн бэрхшээлтэй хүний санаачлан байгуулж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй мэдээлэл хүргэх үйл ажиллагаа явуулдаг радио, телевиз, цахим хуудсыг тусгай зөвшөөрлийн, сувгийн болон долгион эзэмшсэний төлбөрөөс тус тус чөлөөлнө.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНД ҮЗҮҮЛЭХ БОЛОВСРОЛ, ХӨДӨЛМӨР, ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

9 дүгээр зүйл.Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх боловсролын үйлчилгээ

9.1.Хөгжлийн бэрхшээлтэй хүн бүх шатны боловсролын байгууллагад тэгш хамрагдан суралцах, шаардлагатай тохируулгат орчинд хөгжлийн бэрхшээлийн онцлог хэрэгцээнд нийцсэн боловсролын үйлчилгээ авах эрхтэй.

9.2.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд оршин суугаа газартаа хамгийн ойр байрлах өмчийн бүх хэлбэрийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд харьяалал харгалзахгүйгээр тэгш хамрагдан боловсрол эзэмших эрхтэй.

9.3.Монгол Улсын олон улсын гэрээнд зааснаар байнгын асаргаа шаардлагатай 18 насанд хүрсэн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг, эх, эсхүл хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хүсэлтийг үндэслэн сургуулийн дэмжлэгийн багийн шийдвэрээр 21 насанд хүртэл нь ерөнхий боловсролын үйлчилгээнд хамруулж болно.

9.4.Элсэлтийн шалгалтад тэнцэж гадаадын болон дотоодын мэргэжлийн, техникийн, дээд боловсролын байгууллагад суралцах эрхтэй болсон хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн сургалтын зардал, байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй гишүүнтэй өрхийн нэг суралцагчийн танхимын сургалтын төлбөрийг тус тус төрөөс бүрэн санхүүжүүлнэ.

9.5.Хөдөлмөрийн зах зээлд хөгжлийн бэрхшээлийн чиглэлээр хомсдолтой байгаа мэргэжлээр элсэлтийн шалгалтад тэнцэж, дээд боловсролын сургалтын байгууллагад суралцах эрхтэй болсон, Нийгмийн халамжийн тухай хуулийн 3.1.2-т нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг, эсхүл эх, хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн сургалтын төлбөрийг төрөөс бүрэн санхүүжүүлнэ.

9.6.Эрүүл мэнд, боловсрол, хууль эрх зүйн болон барилга байгууламж, авто зам, замын байгууламж, мэдээллийн технологи, харилцаа холбоо, хүний нөөцийн чиглэлээр мэргэжилтэн бэлтгэдэг дээд боловсролын байгууллагын сургалтын хөтөлбөр, агуулгад хөгжлийн бэрхшээлийн тухай ойлголт, мэдлэг олгох, хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй ажиллах арга зүйг тусгана.

9.7.Дээд боловсролын тухай хуулийн 6.1-д заасан боловсролын сургалтын байгууллага нь өмчийн хэлбэр харгалзахгүйгээр дэргэдээ хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид тэтгэлэг олгох, сургалтын төлбөрөөс чөлөөлөх зорилгоор сан байгуулж болно.

9.8.Дээд боловсролын тухай хуулийн 6.1-д заасан боловсролын сургалтын байгууллагад тухайн хичээлийн жилд шинээр элсэн суралцагчдын нэгээс доошгүй хувьд хөгжлийн бэрхшээлтэй хүнийг элсүүлнэ.

9.9.Хөгжлийн бэрхшээлтэй хүнд мэргэжлийн чиг баримжаа, ур чадвар олгох үйл ажиллагаа дагнан явуулж байгаа сургалтын байгууллагын үйл ажиллагааны зардлыг улс, орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ.

9.10.Энэ хуулийн 9.9-д заасан үйл ажиллагааны жишиг зардлыг тооцох журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

9.11.Хөгжлийн бэрхшээлтэй хүний боловсрол эзэмших эрхийг хангах чиглэлээр боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Боловсролын ерөнхий хуульд зааснаас гадна дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

9.11.1.хөгжлийн бэрхшээлтэй хүн боловсролын сургалтын байгууллагад суралцахад шаардлагатай тохируулга, орчин нөхцөлийг бүрдүүлэх, шинэчлэх, шаардлагатай хөрөнгийг төсөвт тусгуулах, хэрэгжүүлэх, багш, боловсон хүчнийг бэлтгэх, хөгжүүлэх;

9.11.2.боловсролын сургалтын байгууллагын танхимын сургалтаар боловсрол эзэмшихэд хүндрэлтэй хөгжлийн бэрхшээлтэй хүнийг танхимын бус сургалтад хамруулах;

9.11.3.хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид зориулсан сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний загварыг батлан тухай бүр шинэчлэх;

9.11.4.сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 6.3-т заасан ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих, сурагчид гарсан ахиц, өөрчлөлт, үр дүнгийн талаарх мэдээллийн сан бүрдүүлэх, холбогдох байгууллагатай мэдээлэл солилцох нөхцөлийг хангах;

9.11.5.хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийг дараагийн шатны боловсрол эзэмшихэд дэмжлэг үзүүлэх “Шилжилтийн хөтөлбөр”-ийг батлан хэрэгжүүлэх.

9.12.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд боловсрол олгох багш, хэл засалч, хөдөлгөөн засалч, хөдөлмөр засалч, дохионы хэлний багш, сэтгэл зүйч, протез, ортезийн техникч зэрэг нэн шаардлагатай мэргэжилтэнг сургалтын төрийн сангийн зардлаар дотоод, гадаадад сургаж бэлтгэнэ.

9.13.Хөгжлийн бэрхшээлийн чиглэлээр эрэлттэй ажил, мэргэжлийн жагсаалтыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн 5 жил тутамд батална.

9.14.Энэ хуулийн 9.13-т заасан жагсаалтын дагуу мэргэжилтэн бэлтгэх арга хэмжээг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хариуцна.

9.15.Бүх шатны боловсролын сургалтын байгууллага нь хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид чанартай боловсролыг хүртээмжтэй олгож, амьдрах ухаан, ур чадварыг үр дүнтэй эзэмшүүлэх бөгөөд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

9.15.1.Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 6.3-т заасан ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний хэрэгжилт, сурагчдад гарсан ахиц, өөрчлөлтийг цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн гүйцэтгэх удирдлага эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн оролцоотой хэлэлцэж, дүгнэлтийг боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага болон энэ хуулийн 27.2.1-д заасан зөвлөлд хүргүүлэх;

9.15.2.хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид Боловсролын ерөнхий хуулийн 8 дугаар зүйлд зааснаас гадна заах арга зүй, арга барил эзэмшсэн дэмжигч, явуулын болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд багшийн туслахын дэмжлэгтэйгээр тэдний онцлог хэрэгцээнд нийцсэн боловсрол эзэмшүүлж, цаашид дэвшин суралцахад туслах;

9.15.3.хөгжлийн бэрхшээлтэй хүний онцлог хэрэгцээнд нийцсэн шаардлагатай тохируулгатай, хүртээмжтэй орчинд суралцагчийн ахицыг үнэлэх болон элсэлтийн шалгалтыг зохион байгуулах, шаардлагатай тохиолдолд нэмэлт цаг олгох;

9.15.4.хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид Боловсролын ерөнхий хуулийн 11.6-д заасан дэмжих үйлчилгээ үзүүлэх.

9.16.Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид Боловсролын ерөнхий хуулийн 11.6-д заасан дараах дэмжих үйлчилгээг цогц байдлаар үзүүлнэ:

9.16.1.суралцах чадвар, хөгжлийн түвшинг үнэлэх;

9.16.2.боловсрол эзэмшихэд шаардлагатай, түүний онцлог хэрэгцээнд нийцсэн сургалтын, харилцааны арга зүй, хэлбэрийг ашиглах;

9.16.3.хөгжүүлэх, сэргээн засах;

9.16.4.боловсролын сургалтын байгууллагад ирэх, буцах унаагаар хангах эсхүл унааны зардлын хөнгөлөлт үзүүлэх, боловсролын сургалтын байгууллагын орчинд хувийн хөдөлгөөнт байдлыг хангах, хооллох зэрэгт туслах;

9.16.5.эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид сургалтын арга зүйн чиглэлээр зөвлөн туслах.

9.17.Энэ хуулийн 9.16-д заасан дэмжих үйлчилгээ үзүүлэх аргачлал, жишиг үнэ, хуулийн этгээд, иргэнд тавигдах шаардлагыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

9.21.Энэ хуулийн 9.16-д заасан үйлчилгээнд шаардагдах зардлыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн жил бүрийн төсөвтөө тусгана.

9.22.Хөгжлийн бэрхшээлтэй хүний сурч боловсрох эрхийг хангах чиглэлээр Нийгмийн халамжийн сангаас дараах дэмжлэгийг үзүүлнэ:

9.22.1.хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, түүний эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, насан туршийн суралцахуйн төв болон хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв, өдөр өнжүүлэх төв, хүүхэд харах үйлчилгээн болон бусад нийгмийн халамж, асрамжийн үйлчилгээний байгууллагад хамрагдахад ирж, очих унааны зардлыг хөнгөлөх, эсхүл тусгай автобусаар үйлчлэх;

9.22.2.орон нутгаас албан боловсрол эзэмших зорилгоор аймаг, нийслэлд ирж сургуульд суралцах хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, түүний эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид ирж, очих унааны зардлыг жилд нэг удаа олгох;

9.22.3.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн болон байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүний нэг хүүхдийн цэцэрлэгийн хоолны зардлын төлбөрт хөнгөлөлт үзүүлэх.

10 дугаар зүйл. Монгол дохионы хэл

10.1. Монгол дохионы хэл бол сонсголгүй хүний албан ёсны хэл мөн.

10.2. Сонсголын бэрхшээлтэй хүн дохионы хэлээрээ боловсрол эзэмших, нийгмийн бүхий л харилцаанд оролцох эрхтэй.

10.3. Энэ хуулийн 10.1-т заасан дохионы хэлийг тухайлсан хуулиар зохицуулна.

10.4. Өмчийн бүх хэлбэрийн байгууллага нь сонсголын бэрхшээлтэй хүн монгол дохионы хэлээр харилцах нөхцөлийг бүрдүүлж, дохионы хэлний хэлмэрч, орчуулагчийн үйлчилгээгээр хангана.

~~10.5. Монгол дохионы хэлний хэлмэрч, орчуулагч бэлтгэх сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний загварыг мэргэжлийн байгууллагын саналыг үндэслэн боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.~~

~~10.6. Дохионы хэлмэрч, орчуулагч бэлтгэх ажлыг сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй иргэдийн эрх, эрх ашгийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг мэргэжлийн байгууллагатай хамтран боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага зохион байгуулна.~~

~~10.7. Монгол дохионы хэлийг эзэмшүүлэх, сургах, судлах, хэрэглэх, хамгаалах, хөгжүүлэх, түүний хэрэгжилтийг хангах чиг үүргийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэдэх Хэлний бодлогын үндэсний зөвлөл хэрэгжүүлнэ.~~

~~10.8. Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн дэргэд Дохионы хэлний хөгжлийн орон тооны бүс дэд зөвлөл /цаашид "дэд зөвлөл" гэх/ ажиллах ба дэд зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг Хэлний бодлогын үндэсний зөвлөл батална.~~

~~10.9. Бүх түвшний боловсролын сургалтын байгууллага сонсголын бэрхшээлтэй хүн монгол дохионы хэл болон бичгийн монгол хэлний хосолсон хөтөлбөрөөр боловсрол эзэмших нөхцөлийг бүрдүүлнэ.~~

~~10.10. Энэ хуулийн 10.9-д заасан хөтөлбөрийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батлан хэрэгжүүлнэ.~~

11 дүгээр зүйл. Брайль үсэг

11.1. Харааны бэрхшээлтэй хүн брайль бичгийг ашиглан боловсрол эзэмших, нийгмийн бүхий л харилцаанд оролцох эрхтэй.

11.2. Бүх түвшний боловсролын сургалтын байгууллага харааны бэрхшээлтэй хүн брайль бичиг болон бусад технологи ашиглан боловсрол эзэмших нөхцөлийг бүрдүүлнэ.

11.3. Брайль үсгийн стандартыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан байгууллага батална.

11.4. Өмчийн бүх хэлбэрийн байгууллага нь харааны бэрхшээлтэй хүн брайль бичгээр бүтээгдэхүүн, үйлчилгээний талаарх мэдээлэл авах нөхцөлийг бүрдүүлнэ.

12 дугаар зүйл. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих

12.1.Хөгжлийн бэрхшээлтэй хүн хөдөлмөр эрхлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд хамрагдах, цалин хөлс, нөхөн олговор авах, албан тушаал дэвших эрхтэй.

12.2.Иргэн, хуулийн этгээд нь хөгжлийн бэрхшээлтэй хүний онцлог хэрэгцээнд нийцсэн шаардлагатай тохируулга бүхий ажлын байрыг Хөдөлмөрийн тухай хуулийн 144.1-д заасны дагуу бий болгож ажиллуулах үүрэгтэй.

12.3.Хөгжлийн бэрхшээлтэй хүний бизнесийг төрөөс татвар, санхүүгийн бодлогоор дэмжинэ.

12.4.Хөгжлийн бэрхшээлтэй хүн ажлын байрны нээлттэй сонгон шалгаруулалтад оролцоходоо бэрхшээлийн онцлог хэрэгцээ, шаардлагад нийцсэн шаардлагатай тохируулгаар хангагдах, нэмэлт цаг ашиглах эрхтэй.

12.5.Хөгжлийн бэрхшээлтэй хүн энэ хуулийн 12.3-т заасан хэрэгцээ, шаардлагын талаар хүсэлт гаргасан тохиолдолд сонгон шалгаруулалт явуулж байгаа байгууллага хүсэлтийг хүлээн авч, шийдвэрлэнэ.

12.6.Иргэн, хуулийн этгээд нь хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөрлөх эрхийг хангахдаа энэ хуулийн 6.4-т заасан үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

12.7.Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр төрөөс дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

- 12.7.1.ажлын байранд зуучлах;
- 12.7.2.хөдөлмөр эрхлэлтийн цогц үйлчилгээнд хамруулах;
- 12.7.3.санхүүгийн дэмжлэг үзүүлэх
- 12.7.4.зорилтот ажлын байр бий болгох, хөгжүүлэх;
- 12.7.5.бусад.

Тайлбар: Хөдөлмөр эрхлэлтийн цогц үйлчилгээ гэж хөгжлийн бэрхшээлтэй хүн хөдөлмөрөөрөө орлого олох хэрэгцээнд суурилсан, ажлын байраар хангахад чиглэсэн мэргэжлийн чиг баримжаа, ур чадвар олгох, ажлын байранд зуучлах, дадлагажуулах, шаардлагатай тохируулгат ажлын байр бий болгох, санхүүгийн, сэтгэлзүйн, нийгмийн дэмжлэг үзүүлэх, ажил олгоогчид мэдлэг олгох, чадавхжуулах зэрэг цогц арга хэмжээг ойлгоно.

12.8.Иргэн, хуулийн этгээд ажлын байранд ажиллахад нэмэлт дэмжлэг, ур чадвар шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажлын байраар хангасан тохиолдолд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд заасны дагуу ажлын байранд дадлагажуулах үйлчилгээг авч болно.

12.9.Энэ хуулийн 12.7-д заасан ажлын байранд дадлагажуулагч нь арга зүйн сургалтад хамрагдсан эрх бүхий этгээд бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажлын байранд дагалдуулан сургах, мэргэжлийн ур чадвар эзэмшүүлэх, хамт олны хөгжлийн бэрхшээлтэй хүнд хандах хандлагыг бэхжүүлэхэд чиглэсэн үйлчилгээг үзүүлнэ.

12.10.Ажлын байрны дадлагажуулагч бэлтгэх, ажиллуулах журмыг хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага батална.

12.11.Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр төрийн захиргааны төв байгууллага дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

12.11.1.хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийг боловсруулан Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд санд хөрөнгө хуваарилах санал бэлтгэн эрх бүхий байгууллагад хүргүүлэх;

12.11.2.хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байраар хангахад чиглэсэн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, иргэн, хуулийн этгээдээс хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажлын

байраар хангах талаар гаргасан аливаа санаачилгыг дэмжих, урамшуулах, алдаршуулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

12.11.3.шаардлагатай тохируулга бүхий хүртээмжтэй ажлыг бий болгох, үнэлэх аргачлал, тохируулгын жагсаалт, холбогдох стандарт, шаардлагыг батлах;

12.10.4.хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хөдөлмөрийн нөхөн сэргээх үйлчилгээг үзүүлэх тогтолцоог бүрдүүлэх, холбогдох журам, жишиг үнийг батлах.

12.11. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр иргэн, хуулийн этгээд дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

12.11.1.Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийн хэрэгжилтийг хангах;

12.11.2.хөгжлийн бэрхшээлтэй хүн ажиллахад аливаа хэлбэрийн саад бэрхшээлгүй, хүртээмжтэй орчинг бүрдүүлэх, тохируулгаар хангах;

12.11.3.байгууллагын хөдөлмөрийн харилцааг зохицуулах бичиг баримтад хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, хамгааллыг сайжруулах зохицуулалтыг тусган хэрэгжүүлэх;

12.11.4.ажиллагчдынхаа хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт, хандлагыг сайжруулахад чиглэсэн сургалт, нөлөөллийн ажлын төлөвлөгөөг батлан хэрэгжилтийг хангах;

12.11.5.нийгмийн хариуцлагын хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжил, дэмжихэд чиглэсэн санал санаачилга гаргах, байгууллага, иргэний гаргасан санаачилгыг дэмжих.

12.12.Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд сангаас дараах дэмжлэгийг үзүүлнэ:

12.12.1.өөртөө ажлын байр бий болгосон хөгжлийн бэрхшээлтэй хүнд ажлын багаж, тоног төхөөрөмж, материал болон бусад шаардлагатай хэрэгслийг худалдан авахад нь нэг удаа санхүүгийн дэмжлэг үзүүлэх;

12.12.2.хөгжлийн бэрхшээлтэй хүн мэргэжил эзэмшиж, ажлын байртай болсон бол шаардлагатай тохируулга хийх, тоног төхөөрөмж, туслах хэрэгслийг худалдан авахад нь ажил олгогчид нэг удаагийн дэмжлэг үзүүлэх;

12.12.3.оюуны болон хавсарсан бэрхшээлийн улмаас ажлын байрны шаардлага хангахгүй хөгжлийн бэрхшээлтэй хүнд зорилтот ажлын байр бий болгох, ажлын байраа өргөтгөх, техник технологи шинэчлэх, турших, нэвтрүүлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх;

12.12.4.хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхэлж байгаа бизнес, тэдний үүсгэл, санаачилгаар байгуулагдсан аж ахуйн нэгжийг санхүүгийн болон хууль тогтоомжид заасан бусад нөхцөлөөр дэмжих;

12.12.5.хөгжлийн бэрхшээлтэй хүн, байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид орлого олох, ажлын байртай болоход нь дэмжлэг үзүүлэх;

12.12.6.хөгжлийн бэрхшээлтэй хүн оролцсон мэргэжлийн ур чадварын тэмцээнийг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх;

12.12.7.мэргэжлийн ур чадварын бүс, тив, дэлхийн тэмцээнд оролцох эрх авсан хөгжлийн бэрхшээлтэй хүн, түүний дасгалжуулагч, хувийн туслах, хөтөчийн, замын болон амьжиргааны зардал, тэмцээний төлбөр хураамж төлөхөд дэмжлэг үзүүлэх;

12.12.8.хууль тогтоомжид заасан бусад дэмжлэг.

12.13.Энэ хуулийн 12.12.7-д заасан тэмцээнд амжилттай оролцсон хөгжлийн бэрхшээлтэй хүнд урамшуулал олгох журмыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

12.14.Энэ хуулийн 12.10.4-т заасан ажлын байрны тохируулгыг үнэлэх, ажлын байрны тохируулга хийх үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх ашгийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагаар гэрээлэн гүйцэтгүүлж болно.

12.15 Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажлын байртай болгосон ажил олгогчийг тухайн ажлын байраар хангасан хүний Нийгмийн даатгалын тухай хуульд заасан ажил олгогчийн цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлээс 24 хүртэл сарын хугацаанд чөлөөлөх ба журмыг Засгийн газар батална.

13 дугаар зүйл. Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ

13.1.Хөгжлийн бэрхшээлтэй хүн шаардлагатай тохируулгат орчинд хөгжлийн бэрхшээлийн онцлог хэрэгцээнд нийцсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах эрхтэй.

13.2.Төрөөс эрүүл мэндийг дэмжих, хөгжлийн бэрхшээл үүсэхээс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, оношлох, үнэлэх, эмчлэх, сувилах, сэргээн засах, хөнгөвчлөх, шаардлагатай эм, эмийн бүтээгдэхүүн, туслах бүтээгдэхүүнээр хангах цогц арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

13.3.Өмчийн хэлбэр харгалзахгүйгээр бүх шатны эрүүл мэндийн байгууллага хөгжлийн бэрхшээлтэй хүнд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэхдээ тэдний онцлог хэрэгцээ, шаардлагыг хангасан шаардлагатай тохируулга, хүртээмжтэй орчин, нөхцөлийг бүрдүүлнэ.

13.4.Бүх шатны эрүүл мэндийн байгууллага хөгжлийн бэрхшээлтэй хүнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэхдээ аливаа хүчирхийллийн арга хэлбэр хэрэглэхийг хориглоно.

13.5.Ганц бие, асран хамгаалагчгүй оюун, сэтгэцийн бэрхшээлтэй хүний онцлог хэрэгцээнд нийцсэн эрүүл мэндийн болон урт хугацаагаар асрах төрөлжсөн үйлчилгээ үзүүлэх төвтэй байна.

13.6.Энэ хуулийн 13.6-д заасан төвийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд байгуулж, эрүүл мэндийн болон хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төсвөөс тус тус санхүүжүүлнэ.

13.7.Энэ хуулийн 13.6-д заасан төвөөр үйлчлүүлэгчийн Нийгмийн халамжийн тухай хуулийн 19.5-д заасан зардлыг Нийгмийн халамжийн сангаас олгоно.

13.8.Энэ хуулийн 13.6-т заасан төвийн үйлчилгээнд хамрагдаж байгаа хүнийг Эрүүл мэндийн тухай хуулийн 3.1.25-д заасан эрүүл мэндийн урт хугацааны тусламж, үйлчилгээнд давхардуулан хамруулахгүй.

13.9.Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгч байгууллага нь хөгжлийн бэрхшээлтэй хүнд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг цаг алдалгүй, чанартай, тэгш хүртээмжтэй хүргэж шаардлагатай тохиолдолд хамгийн ойр байрлах дараагийн шатлалын эрүүл мэндийн байгууллагад шилжүүлнэ.

13.10.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах эрхийг хангах чиглэлээр эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

13.10.1.хөгжлийн бэрхшээлтэй хүнд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай тохируулга, орчин нөхцөлийг бүрдүүлэх, шинэчлэх, дэвшилтэт техник, тоног төхөөрөмж, туслах технологи нэвтрүүлэхэд шаардлагатай хөрөнгө оруулалтыг төсөвт тусгуулах, хэрэгжүүлэх, эмч, боловсон хүчнийг бэлтгэх, мэргэшүүлэх, хөгжүүлэх;

Тайлбар: “туслах технологи” гэж туслах хэрэгслэгдэхүүн үйлдвэрлэх, угсрах, тааруулах, тохируулах, ашиглах, засварлах үйлчилгээ үзүүлэх тогтолцоог;

13.10.2.хөгжлийн бэрхшээлтэй хүний эрүүл мэндийн тогтвортой байдлыг хангах, амь насыг хамгаалах зайлшгүй шаардлагаар тасралтгүй, байнга хэрэглэдэг эм, эмийн хэрэгслийн нөөцийг бүрдүүлж, хүртээмжтэй түгээх нэгдсэн бодлогоор хангах;

13.10.3.хөгжлийн бэрхшээлтэй хүнд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлдэг болон эрэлттэй мэргэжлийн хүний нөөцийн судалгаа гаргаж, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад жил бүрийн 2 дугаар сарын 15-ны дотор хүргүүлэх;

13.10.4.ургийн гажиг болон 0-5 насны хүүхдийн хөгжлийн хоцрогдлыг эрт илрүүлэх, урьдчилан сэргийлэх, оношлох, эмчлэх тогтолцоог бүрдүүлэх, хяналт тавих;

13.10.5.хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг илрүүлсэн даруйд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүлэх;

13.10.6.хөгжлийн бэрхшээлтэй хүний бэлгийн болон нөхөн үржихүйн эрхийг хангахад чиглэсэн эрүүл мэндийн боловсрол олгох сургалт, үйлчилгээнд хөгжлийн бэрхшээлтэй хүн, түүний эцэг, ах, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, гэр бүлийн гишүүнийг хамруулах.

13.11.Энэ хуулийн 13.11.1-д заасан тусламж, үйлчилгээ үзүүлэхэд шаардагдах техник, тоног төхөөрөмж, эм, урвалж бодис, эрт илрүүлгийн хэрэгсэл, хүртээмжтэй орчныг бүрдүүлэхэд шаардагдах зардлыг бүх шатны эрүүл мэндийн байгууллагын төсөвт тусган хэрэгжүүлнэ.

13.12.Энэ хуулийн 13.11.2-т заасан эм, эмийн хэрэгслийн жагсаалтыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

13.13.Эрүүл мэндийн байгууллага нь хөгжлийн бэрхшээлтэй хүнд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн багтай байна.

13.14.Мэргэжлийн багийн дүрэм, урамшуулал олгох журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

13.15.Энэ хуулийн 13.11.6-д заасан үйлчилгээг хуулийн этгээдээр гэрээлэн гүйцэтгүүлж болно.

13.16.Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүрээнд Нийгмийн халамжийн сангаас дор дурдсан үйлчилгээг үзүүлнэ:

13.16.1.байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүн, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд дотоодын рашаан, сувилалд дараалал харгалзахгүйгээр сувилуулах;

13.16.2.байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүн тухайн орон нутагтаа эмнэлгийн тусламж, үйлчилгээ авах, шинжилгээ хийх боломжгүй болохыг аймгийн нэгдсэн эмнэлгийн нарийн мэргэжлийн эмч нарын хяналтын зөвлөлөөс тодорхойлсон шийдвэрээр нийслэлд ирж эмчлүүлэх, нарийн мэргэжлийн шинжилгээ хийлгэх тохиолдолд хот хоорондын зорчигч тээврийн жишиг үнийг үндэслэн тухайн хөгжлийн бэрхшээлтэй хүнд унааны зардлыг жилд нэг удаа 100 хувь, хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигчид 50 хувийг нөхөн олгох.

13.17.Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүрээнд Эрүүл мэндийн даатгалын сангаас доор дурдсан үйлчилгээг үзүүлнэ:

13.17.1.хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, хөдөлгөөний бэрхшээлтэй хөгжлийн бэрхшээлтэй хүн эмнэлгийн магадлагаагаар дотоодод усан эмчилгээ хийлгэсэн бол эмчилгээний төлбөрийн 70 хувийг нөхөн олгох;

13.17.2.магадлан итгэмжлэгдсэн дотоодын рашаан сувилалд сувилуулахад:

13.17.2.а.хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн зардлыг 100 хувь;

13.17.2.б.хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүнийг асран халамжилж буй нэг хүний зардлын 50 хувь;

13.17.2.в.үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас хөнгөлөлт авах эрх үүсээгүй хөгжлийн бэрхшээлтэй хүний зардлын 50 хувь.

13.17.3.асаргаа сувилгааны хэрэгсэл, ариун цэвэр-эрүүл ахуйн материалаар хангах;

13.17.4.хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн протез, ортез, тусгай хэрэгслийн зардлыг 100 хувь;

13.17.5.хөгжлийн бэрхшээлтэй хүний урт хугацааны сэргээн засах үйлчилгээний зардлын 80 хүртэл хувь;

13.17.6.холголт, цооролтын үеийн эмчилгээний зардлыг 80 хувийг хариуцах.

Тайлбар:

"Урт хугацааны сэргээн засах үйлчилгээ" гэж Эрүүл мэндийн тухай хуулийн 3.1.21-т заасан цогц үйл ажиллагааг хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээнд тулгуурлан 14 хоноогоос 90 хүртэл хоногийн хугацаанд хүргэхийг;

"асаргаа сувилгааны хэрэгсэл" гэж асруулж байгаа хүний эрүүл мэндийн хэвийн байдлыг хангах, асарч байгаа хүний хөдөлмөрийг хөнгөвчлөх, аюулгүй байдлыг хангах, урьдчилан

сэргийлэх зориулалт бүхий хэрэгслийг; "ариун цэвэр-эрүүл ахуйн материал" гэж хэвтрийн болон байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүний өдөр тутмын эрүүл ахуйн шаардлагыг хангах, зайлшгүй хэрэгцээтэй живх, катетр, катетрийн уут, ариутгалын уусмал, ороох, боох материал, бусад хэрэгслийг.

14 дүгээр зүйл. Туслах хэрэглэгдэхүүнээр хангах

14.1.Хөгжлийн бэрхшээлтэй хүн өөрийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн, бие махбодийн онцлог, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согогт нь тохирсон, чанар, стандартын шаардлага хангасан туслах хэрэглэгдэхүүнээр хангагдах эрхтэй.

14.2.Туслах хэрэглэгдэхүүний зардлыг Үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сан, Эрүүл мэндийн даатгалын сан, Нийгмийн халамжийн сангаас хуульд заасны дагуу тус тус санхүүжүүлнэ.

14.3.Энэ хуулийн 27.2.1-т заасан салбар зөвлөл нь 0-18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн, Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 37.7-д заасан Эрүүл мэндийн магадлалын зөвлөл нь 18 ба түүнээс дээш насны хөгжлийн бэрхшээлтэй хүний онцлог хэрэгцээнд нийцсэн туслах бүтээгдэхүүн олгох шийдвэр гаргана.

14.4.Туслах бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх, хиймэл оюун ухаан ухаанд суурилсан дэвшилтэт технологийг турших, нэвтрүүлэхэд шаардлагатай зардлыг цахим хөгжлийн болон хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын жил бүрийн төсөвт тусгана.

14.5.Туслах хэрэглэгдэхүүний стандарт, шаардлагыг хөгжлийн бэрхшээлтэй хүний болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын саналаар стандарт, хэмжил зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална.

14.3.Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг туслах бүтээгдэхүүнээр хангах зорилгоор Нийгмийн халамжийн сангаас дор дурдсан үйлчилгээг үзүүлнэ:

14.3.1.Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 4.1.10.в-д заасан эмнэлгийн хэрэглэгдэхүүн нь хүүхдийн өсөлтийн улмаас бие эрхтэнд таарахгүй болсон болон эдэлгээний хугацаа дууссан тохиолдолд зардлыг Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн баталсан жагсаалт, төлбөрийн хэмжээний дагуу бүрэн эсхүл хэсэгчлэн санхүүжүүлэх;

14.3.2.Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-т заасны дагуу протез, ортопедийн зардлын төлбөрийг авах эрх үүсээгүй хөгжлийн бэрхшээлтэй иргэний Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 4.1.10.в-д заасан өндөр болон зарим дунд эрсдэлтэй эмнэлгийн хэрэглэгдэхүүний үнийн хөнгөлөлтийг гурван жил тутам нэг удаа Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн баталсан жагсаалт, төлбөрийн хэмжээний дагуу хэсэгчлэн санхүүжүүлэх.

14.4.Эмнэлгийн хэрэглэгдэхүүнээс бусад нэн шаардлагатай туслах хэрэгслийн үнийн хөнгөлөлтийн зардлыг хөгжлийн бэрхшээлтэй иргэний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний төсөвт тусган, хөгжлийн бэрхшээлтэй иргэний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь Засгийн газраас баталсан жагсаалт, олгох давтамж, жишиг үнийг баримтлан хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд болон хараа, сонсголын бэрхшээлтэй хүнд нөхөн олгох.

21.5.Энэ хуулийн 14.3.1, 14.3.2, 14.4-т заасан эмнэлгийн хэрэглэгдэхүүн, нэн шаардлагатай туслах хэрэгслийг гадаад улсад хийлгэсэн эсхүл худалдан авсан бол түүний зардлын төлбөрийг энэ хуулийн 14.3.1, 14.3.2, 14.4-т заасан дотоодод хийлгэсэн жишиг үнийг баримтлан нөхөн олгож болно.

21.6.Энэ хуулийн 14.3.1, 14.3.2-т заасан эмнэлгийн хэрэглэгдэхүүний зардлыг жил бүр нийгмийн халамжийн сангаас Эрүүл мэндийн даатгалын санд шилжүүлж, эрүүл мэндийн даатгалын байгууллагаар дамжуулан санхүүжүүлнэ.

21.7.Энэ хуулийн 14.3.1, 14.3.2-т заасан эмнэлгийн хэрэглэгдэхүүнээр үйлчлэх, олгох журмыг Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл батална.

15 дугаар зүйл.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд үзүүлэх боловсрол, эрүүл мэнд, нийгмийн тусламж, үйлчилгээ

15.1.Төрөөс үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд үнэ төлбөргүй хамрагдах эрхтэй.

15.2.Хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх, оношлох, үнэлэх, түүнд эрүүл мэнд, боловсрол, нийгэм, гэр бүл, олон нийтэд түшиглэн хөгжүүлэх үйлчилгээг хүртээмжтэй хүргэх зорилгоор хүүхдийн хөгжлийн төвийг байгуулан, хөгжлийн хоцрогдолтой хүүхдийн онцлог хэрэгцээнд нийцсэн үйлчилгээ үзүүлэхийг төрөөс дэмжинэ.

15.4.Бүх шатны эрүүл мэндийн байгууллага хүүхдийн хөгжлийн хоцрогдлыг илрүүлсэн даруй үнэлгээ хийж, түүнд тохирсон эрүүл мэндийн болон сувилахуйн тусламж, үйлчилгээ үзүүлэх, нийгмийн халамжийн тусламж, хөнгөлөлт, хөгжлийн дэмжлэгт хамруулах, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг мэдээллээр хангах, холбогдох үйлчилгээнд зуучлана.

15.5.Энэ зүйлийн 15.4-т заасан үйлчилгээ, дэмжлэгийн талаарх мэдээллийг боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага тухай бүр шинэчлэн хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

15.6.Боловсролын үйлчилгээнд хамрагдах боломжгүй хоёроос 18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүнийг энэ хуулийн 27.2.1-д заасан комиссын шийдвэрээр хөгжүүлэх төвийн үйлчилгээнд хамруулна.

15.7.Энэ хуулийн 15.6-д заасан дэмжих үйлчилгээ дараах хэлбэртэй байна:

- 15.7.1.сэргээн засах;
- 15.7.2.боловсрол, хөгжлийн;
- 15.7.3.сэтгэл зүй, сэтгэл заслын;
- 15.7.4. нийгмийн хамгааллын;

15.8.Хүүхдийн нас, бэрхшээлийн онцлог, хэрэгцээ, шаардлагад тулгуурлан энэ зүйлийн 15.7.1-15.7.4-т заасан үйлчилгээг дангаар болон цогцоор, танхимын болон явуулын хэлбэрээр, цагаар болон өдрөөр үзүүлж болно.

15.9.Хөгжүүлэх төв нь дараах шаардлагыг хангасан байна:

15.9.1.төв нь үүсгэн байгуулагчийн өөрийн өмчлөлийн байр, түрээсийн байр, зээлийн байранд үйл ажиллагаа явуулдаг;

15.9.2.байрны гадна, дотоод орчин нь хүүхдийн амь нас, эрүүл мэндэд эрсдэлгүй, хүүхдийг аливаа болзошгүй сөрөг нөлөөлөл, үйлдлээс хамгаалсан хэвийн нөхцөлийг бүрдүүлсэн;

15.9.3.сэргээн засах болон хөгжлийн үйлчилгээг үзүүлэх болон хүүхэд амрах, тоглох, гар угаах, бие засах газар, гал тогоотой;

15.9.4.байрны халаалт, гэрэлтүүлэг, агааржуулалт нь амьдрах хэвийн нөхцөлийг хангасан;

15.9.5.сэргээн засах үйлчилгээнд ашиглах болон асран халамжлах, хамгаалах, хооллох, тоглуулах, амрах үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмж, тавилга, хэрэгслээр хангагдсан;

15.9.6. төвийн нэг ажилтанд ноогдох хүүхдийн тоо 4-өөс ихгүй;

15.9.7.сэргээн засахын мэргэжилтэн, тусгай хэрэгцээт боловсролын багш, тусгай сургалтаар бэлтгэгдсэн туслах ажилтантай.

15.10.Энэ хуулийн 15.9.7-д заасан туслах ажилтан бэлтгэх сургалтыг хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага зохион байгуулна.

15.11.Хөгжүүлэх төвийн үйлчилгээг төлөвлөж зохион байгуулах, туслах ажилтан бэлтгэх суралтад шаардагдах хөрөнгийг хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний төсвийн багцад жил бүр тусгана.

5.12.Хөгжүүлэх төвд үйлчилгээ үзүүлэх, үйл ажиллагааг магадлан итгэмжлэх, хяналт тавих журам, үйлчилгээний жишиг үнэ, эцэг, эх, асран хамгаалагчаас төлөх төлбөрийн дээд хэмжээг хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно.

15.13.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн түвшинг үнэлэх, үнэлгээнд үндэслэн холбогдох үйлчилгээнд холбон зуучлах, үйлчилгээнд хяналт тавих, энэ хуулийн 9.11.5-д заасан Шилжилтийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч хүүхдээ өсгөн бойжуулах, хөгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, чадвар олгох арга хэмжээг төрийн бус байгууллагаар гэрээлэн гүйцэтгүүлж болно.

15.14.Энэ хуулийн 15.13-т заасан арга хэмжээг Төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх журмыг хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

15.15. Энэ хуулийн 15.13-т заасан арга хэмжээг Төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэхэд шаардлагатай хөрөнгийг хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын төсөвт жил бүр тусгана.

15.16.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг гэр бүл, олон нийтэд түшиглэн хөгжүүлэх олон улсад туршигдсан хөтөлбөр, үйлчилгээг боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын салбарын бодлого, үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлнэ.

15.17.Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй гэрлэгчид гэрлэлтээ цуцлуулсан тохиолдолд тэтгэлэг төлөгч нь холбогдох хууль тогтоомжинд заасны дагуу нэмэлт тэтгэлэг төлнө.

15.18.Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй эцэг, эхгүй 18 хүртэлх насны хүүхдийг асарч ажил хөдөлмөр эрхлээгүй хууль ёсны асран хамгаалагч, эсхүл харгалзан дэмжигчийн Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 6.1.1, 6.1.2, 6.1.5-д заасан даатгалын төрөлд даатгуулах бол тухайн үед мөрдөж байгаа сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнд ногдох тэтгэврийн даатгалын шимтгэлийг улсын төсвөөс сар бүр төлнө.

15.19. Нийгмийн халамжийн сангаас хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд дараах дэмжлэгийг үзүүлнэ:

15.19.1.хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд харгалзан дэмжигчийн хамт эх, хүүхдийн амралт, хүүхдийн зусланд амарвал жишиг үнийг харгалзан хүүхдийн эрхийн бичгийн төлбөрийг 100 хувиар, харгалзан дэмжигчийн төлбөрийг 50 хувиар тооцож, жилд нэг удаа олгох;

15.19.2.хүүхдийн бэрхшээлийн хэлбэр, хэрэгцээ шаардлагад үндэслэн Нийгмийн халамжийн тухай хуульд заасан бусад боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээ, хөнгөлөлт, тусламжид хамруулах.

15.20.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, сурч боловсрох, эрүүл мэндээ хамгаалуулах суурь эрхийг зөрчсөн, төрөөс олгосон тэтгэвэр, тэтгэмжийг зориулалтын дагуу ашиглаагүй эх, эцэг, хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигчээр хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд олгосон тэтгэвэр, тэтгэмжийг нөхөн төлүүлнэ.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ НИЙТЛЭГ ЭРХИЙГ ХАНГАХ

16 дугаар зүйл.Хөгжлийн бэрхшээлтэй хүнд хууль зүйн туслалцаа үзүүлэх

16.1.Хөгжлийн бэрхшээлтэй хүн онцлог хэрэгцээндээ нийцсэн хэлбэрээр хууль зүйн зөвлөгөө, өмгөөллийн үйлчилгээг үнэ төлбөргүй авах эрхтэй.

16.2.Шүүх, прокурор, цагдаа, өмгөөлөл, хууль сахиулах байгууллагын барилга байгууламж, үйл ажиллагаа нь хөгжлийн бэрхшээлтэй хүнд саадгүй, хүртээмжтэй, байна.

16.3.Энэ хуулийн 16.2-т заасан байгууллага хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох хөгжлийн бэрхшээлтэй хүнд түүний эрх, үүрэг болон холбогдох мэдээллийг бэрхшээлийн онцлог хэрэгцээнд нийцүүлэн ойлгомжтой, хүртээмжтэй хэлбэрээр бүрэн тайлбарлаж өгнө.

16.4.Төрөөс хөгжлийн бэрхшээлтэй хүн, түүний эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид эрх зүйн боловсрол олгох, хууль зүйн зөвлөгөөг тэдний бэрхшээлийн онцлог хэрэгцээнд тохируулан хүртээмжтэй хүргэх үйл ажиллагаа явуулдаг хүн, хуулийн этгээдэд хууль зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага дэмжлэг үзүүлнэ.

16.5.Энэ хуулийн 16.2-т заасан байгууллага нь текст уншигч, бичигч, дохионы хэлний хэлмэрч, орчуулагчийн болон энэ хуулийн 16.4-т заасан үйлчилгээний зардлыг жил бүрийн төсөвтөө тусгана.

16.6.Энэ хуулийн 16.5-д заасан үйлчилгээг үзүүлэх хүн, хуулийн этгээдэд тавих шаардлага, дэмжлэгийн төрөл, хэлбэр, жишиг үнийг тогтоосон журмыг Хууль зүйн, хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

16.7.Хөгжлийн бэрхшээлтэй хүн хууль зүйн туслалцаа, өмгөөллийн үйлчилгээ авахтай холбогдсон энэ хуульд зааснаас бусад харилцааг холбогдох бусад хуулиар зохицуулна.

17 дугаар зүйл.Хөгжлийн бэрхшээлтэй хүний улс төрийн оролцоог хангах

17.1.Бүх шатны сонгуульд хөгжлийн бэрхшээлтэй хүн саналаа бие даан, чөлөөтэй, нууцаар өгөх орчин, нөхцөлийг бүрдүүлсэн байна.

17.2.Бүх шатны сонгуульд оролцогч нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн сурталчилгаа нь хөгжлийн бэрхшээлтэй сонгогчийн онцлог хэрэгцээ, шаардлагад нийцсэн, хүртээмжтэй байна.

17.3.Хөгжлийн бэрхшээлтэй хүн бүх шатны сонгуульд нэр дэвшихэд улс төрийн нам, эвсэл холбогдох хуульд заасны дагуу дэмжих үүрэгтэй.

17.4.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах талаар улс төрийн нам, эвсэл, бие даагч бодлого, мөрийн хөтөлбөртөө тусгана.

17.5.Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг Улсын Их Хурал, бүх шатны Иргэдийн Төлөөлөгчдийн хуралд нэр дэвшүүлэх доод хязгаарыг холбогдох хуулиар баталгаажуулна.

18 дугаар зүйл.Хувийн нууцыг хүндэтгэх

18.1.Хөгжлийн бэрхшээлтэй хүний захидал харилцаа, эрүүл мэнд, эд хөрөнгө, гэр бүлийн нууц болон нэр төр, алдар хүндийг Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжоор хамгаална.

18.2.Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үйлчилгээ үзүүлж байгаа аливаа этгээд хөгжлийн бэрхшээлтэй хүний нууцыг задруулахыг хориглоно.

19 дүгээр зүйл.Хөгжлийн бэрхшээлтэй хүний биеийн тамир, спортын үйл ажиллагааг дэмжих

19.1.Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг Биеийн тамир, спортын тухай хууль болон олон улсын спортын байгууллагын ангилал, дүрэм, стандартад заасныг баримтлан биеийн тамир, спортын арга хэмжээнд оролцуулна .

19.2.Хөгжлийн бэрхшээлтэй хүний биеийн тамир, спортын арга хэмжээг зохион байгуулахад биеийн тамир, спортын асуудал хариуцсан төрийн байгууллага дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

19.2.1.хөгжлийн бэрхшээлтэй хүнийг идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх, спортын тэмцээн, наадамд оролцоход бүх шатны биеийн тамир, спортын байгууллага шаардлагатай тохируулга, хүртээмжтэй орчин, нөхцөл бүхий заал талбай, тоног төхөөрөмж, спортын анагаах ухаан, эрдэм шинжилгээний тусламж үйлчилгээгээр дэмжлэг үзүүлэх;

19.2.2.хөгжлийн бэрхшээлтэй тамирчин паралимп, тусгай олимп, дифлимп, тив, дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд холбогдох журмын дагуу шалгаран оролцоход нь тамирчин, түүний хувийн туслах, хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигч, дохионы орчуулагчид шаардагдах зардлыг улсын төсөвт тусгах;

19.2.3.паралимп, тусгай олимп, дифлимп, тив, дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд Монгол Улсаа төлөөлөн амжилттай оролцсон тамирчин, түүний дасгалжуулагчид Биеийн тамир, спортын тухай хуулийн 33.1.1-д заасан мөнгөн шагнал олгох;

19.2.4.улсын хэмжээний хүүхдийн, оюутны, үндэсний спортын наадам болон Биеийн тамир, спортын тухай хуулийн 11.1.10-т заасны дагуу эрх авсан спортын холбооноос зохион байгуулах улсын аварга шалгаруулах тэмцээнд амжилттай оролцож, медаль хүртсэн хөгжлийн бэрхшээлтэй тамирчин, түүний дасгалжуулагчид Биеийн тамир, спортын тухай хуулийн 33.1.1-д заасан мөнгөн шагнал олгох;

19.2.5.хөгжлийн бэрхшээлтэй хүнийг нас, биеийн онцлогт нь тохирсон идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллүүлэх чиглэлээр сургалт, сурталчилгаа нөлөөллийн ажлыг зохион байгуулах.

19.3.Паралимп, тусгай олимп, дифлимп, тив болон дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд Монгол Улсаа төлөөлөн амжилттай оролцож, медаль авсан хөгжлийн бэрхшээлтэй тамирчинд түүний оролцсон тэмцээний зохион байгуулагдах давтамжийн хугацаанд ногдох нийгмийн халамжийн тэтгэвэртэй тэнцэх хэмжээний тусламжийг тухайн тэмцээний төрөлд нэг удаа олгоно.

19.4.Энэ хуулийн 19.3-т заасан тусламжид шаардагдах зардлыг хөгжлийн бэрхшээлтэй асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын төсөвт жил бүр тусгана.

19.5.Хөгжлийн бэрхшээлтэй хүний биеийн тамир, спортын үйл ажиллагааг дэмжихтэй холбогдсон энэ хуульд зааснаас бусад харилцааг Биеийн тамир, спортын тухай хууль болон холбогдох бусад хуулиар зохицуулна.

19.6. Биеийн тамир, спортын тухай хууль болон холбогдох бусад хуулиар шагнал, урамшуулал олгож байгаа шалтгаанаар амжилт гаргасан хөгжлийн бэрхшээлтэй хүний энэ хуулийн 19.3-т заасан тусламжийг зогсоохыг хориглоно.

20 дугаар зүйл.Хөгжлийн бэрхшээлтэй хүний соёл, урлагийн үйл ажиллагааг дэмжих

20.1.Хөгжлийн бэрхшээлтэй хүн дараах соёл, урлагийн үйлчилгээнд хамрагдах эрхтэй:

20.1.1.авьяас чадвараа хөгжүүлэх;

20.1.2.соёл, урлагийн бүтээл туурвих;

20.1.3.уралдаан тэмцээн, арга хэмжээнд оролцох;

20.1.4.соёл, урлагийн үйлчилгээг хүртээмжтэй авах;

20.1.5.соёл, урлагийн үйлчилгээ үзүүлэх.

20.2.Соёлын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага дараах арга хэмжээг хэрэгжүүлж, шаардагдах хөрөнгийг жил бүрийн төсөвтөө тусгана:

20.2.1.хүний эрх, эрх чөлөө, эрх тэгш байдлыг хүндэтгэсэн, хөгжлийн бэрхшээлийн талаар эерэг зан үйл, хандлагыг нийгэмд төлөвшүүлэхэд чиглэсэн бодлогыг тодорхойлж, хэрэгжилтэд хяналт тавих, сурталчлах ажлыг зохион байгуулах;

20.2.2.хөгжлийн бэрхшээлтэй хүнийг соёл, урлагийн бүс, тив, дэлхийн чанартай тэмцээн, уралдаанд оролцоход бүх шатны соёл, урлагийн байгууллага шаардлагатай тохируулга, хүртээмжтэй орчин, нөхцөл бүхий заал талбай, тоног төхөөрөмжөөр хангаж, дэмжлэг үзүүлэх;

20.2.3.бүс, тив, дэлхийн чанартай соёл, урлагийн уралдаан, тэмцээнд Монгол Улсаа төлөөлөн амжилттай оролцож, медаль авсан хөгжлийн бэрхшээлтэй хүнд Засгийн газраас баталсан журамд заасан урамшууллыг 1.5 дахин нэмэгдүүлэн олгох;

20.2.4.соёл урлагийн бүтээлийг хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй хэлбэрт хөрвүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

20.2.5.соёл, урлагийн чиглэлээр хөдөлмөр эрхэлж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүнд шаардлагатай багаж, техник, хэрэгслээр хангахад дэмжлэг үзүүлэх;

20.2.6.хөгжлийн бэрхшээлийн талаар сөрөг агуулга бүхий соёл, урлагийн арга хэмжээ, аливаа уран бүтээл, утга зохиолыг нийтэд түгээхээс урьдчилан сэргийлэх, хяналт тавих, хязгаарлалт тогтоох.

20.3.Бүх шатны соёл, урлагийн байгууллага хөгжлийн бэрхшээлтэй хүн уран бүтээлээ олон нийтэд толилуулах, сурталчлах, түгээн дэлгэрүүлэхэд байр, талбайн түрээсийн төлбөрөөс 50 хүртэл хувийн хөнгөлөлт үзүүлнэ.

20.4.Өмчийн бүх хэлбэрийн соёл, урлагийн байгууллагын барилга, байгууламж, үзвэр үйлчилгээ нь шаардлагатай тохируулга бүхий, саадгүй, хүртээмжтэй байна.

20.5. Энэ хуулийн 20.4-д заасан тохируулгын зардлыг тухайг байгууллагын төсөвт тусган үе шаттайгаар саадгүй, хүртээмжтэй болгох төлөвлөгөөг батлан хэрэгжүүлнэ.

ТАВДУГААР БҮЛЭГ **ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ НИЙГМИЙН ХАМГААЛАЛ**

21 дүгээр зүйл.Нийгмийн хамгаалал хүртэх эрх

21.1.Хөгжлийн бэрхшээлтэй хүн холбогдох заасан тэтгэвэр, тэтгэмжид хамрагдахаас гадна хоол хүнс, хувцас, орон байр, нийгэм, ахуйн зайлшгүй шаардлагатай үйлчилгээг авах, өөрийн болон гэр бүлийнхээ эрүүл мэнд, аж амьдралыг тэтгэхэд хүрэлцэхүйц амьжиргаатай байх эрхтэй.

21.2.Хөгжлийн бэрхшээлтэй эцэг, эх хүүхдээ асрах, өсгөн хөгжүүлэхэд шаардлагатай дэмжлэг, үйлчилгээ авах эрхтэй.

21.3.Хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн баталгааг хангах, орон сууцаар хангах бодлогыг Засгийн газрын богино болон дунд хугацааны бодлогод тусган хэрэгжүүлнэ.

21.4.Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг орон байраар хангах, орон байрны нөхцөлийг сайжруулах чиглэлээр аймаг, нийслэлийн Засаг дарга дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

21.4.1.халамжийн, түрээсийн, амины орон сууцны хөтөлбөр хэрэгжүүлэх, ипотекийн зээлд хөнгөлөлттэй нөхцөлөөр хамруулахад шаардагдах хөрөнгийг жил бүр төсөвтөө тусгах;

21.4.2.гэр хороолол, хувийн орон сууцанд амьдарч байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүний орон байрыг инженерийн дэд бүтцэд холбох болон тохируулгаар хангах зорилгоор нэг удаагийн дэмжлэг үзүүлэх;

21.4.3.анх удаа гэр бүл болсон хөгжлийн бэрхшээлтэй хосод орон сууц болоход зориулж нэг удаа 20 сая хүртэл төгрөгийн буцалтгүй тусламж олгох;

21.4.4.Энэ хуулийн 21.3.1, 23.3.2-т заасан арга хэмжээнд хамрагдах хүний хүсэлтийг хүлээн авч бүртгэх, мэдээллийн сан байгуулах.

21.5.Хөгжлийн бэрхшээлтэй хүн хамтын гэрт болон хүй олонтойгоо хамтран амьдрах хэлбэрийг төрөөс дэмжинэ.

21.6.Энэ хуулийн 21.5-д заасан амьдрах хэлбэрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай орон байраар хангах зардлыг Хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын жил бүрийн төсөвт тусгана.

21.7.Энэ хуулийн 21.5-д заасан амьдрах хэлбэрт дэмжлэг үзүүлэх журмыг Засгийн газар батална

21.8.Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүнд олгох тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээнд тохируулан Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу ялгаатай тогтоож болно.

21.9. Нийгмийн халамжийн тухай хуулийн 17 дугаар зүйлд заасан Бие даан амьдрах чадавхыг дэмжих урт хугацааны үйлчилгээнд хамрагдах хүсэлт гаргасан хөгжлийн бэрхшээлтэй хүнийг дараалал харгалзахгүйгээр хамруулна.

21.10.Хөгжлийн бэрхшээлтэй хүн Нийгмийн даатгалын сангаас өндөр насны тэтгэвэр тогтоолгосон бол Нийгмийн халамжийн тухай хуульд заасан бусад тэтгэмж, үйлчилгээ, хөнгөлөлт, тусламж, дэмжлэгт үргэлжлүүлэн хамрагдана.

21.11.Хөгжлийн бэрхшээлтэй даатгуулагч үйлдвэрлэлийн осолд орсон, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас биеийн эрүүл мэндийн байдал нь дордсон бол Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд заасан хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэврийн хэмжээг хоёр дахин нэмэгдүүлж олгоно.

21.12.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан тэтгэмж авах эрх үүсээгүй хөгжлийн бэрхшээлтэй хүн нас барвал Нийгмийн даатгалын сангаас нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмжтэй тэнцүү хэмжээний мөнгөн тусламж олгоно.

21.13.Хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн хамгааллын хүрээнд Нийгмийн халамжийн сангаас доор дурдсан тусламж, хөнгөлөлтийг үзүүлнэ:

21.13.1.хараагүй хүний брайль үсгээр бичсэн захидал, ил захидал, брайль хэвлэл, хараагүй хүний зориулалттай техник, тоног төхөөрөмж, материал хэрэгсэл зэрэг 10 кг хүртэлх илгээмжийг дотоодод хүргүүлсэн зардлыг жилд нэг удаа нөхөж олгох;

21.13.2.байнгын асаргаа шаардлагатай 18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, харах, ярих, сонсох чадвараа бүрэн алдсан болон одой хүн болон байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүнд төрийн түрээсийн орон сууцанд амьдардаг бол түрээсийн төлбөрийн зөрүү, төвлөрсөн инженерийн дэд бүтэц бүхий орон сууцанд амьдардаг бол орон сууцны хөлс төлөхөд, хэрэв нийтийн халаалтгүй сууц, гэрт амьдардаг бол түлш худалдан авахад нь жилд нэг удаа мөнгөн тусламж олгох;

21.13.3.18-аас дээш насны харах, ярих, сонсох чадвараа бүрэн алдсан байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй болон оюуны бэрхшээлтэй хүний харилцаа холбооны зардалд хөнгөлөлт үзүүлэх.

21.13.4.хувийн туслах үйлчилгээ болон өдрөөр асрах, гэрээр асрах, түр болон урт хугацаагаар асрах асаргааны хувилбарт үйлчилгээ үзүүлэх;

21.14.Энэ хуулийн 21.13-д заасан Нийгмийн халамжийн сангаас олгох хөнгөлөлтийн хэмжээ, олгох журмыг Засгийн газар батална.

21.15.Хөгжлийн бэрхшээлтэй иргэн нийслэл, аймгийн төвийн нийтийн тээврийн хэрэгсэл /таксинаас бусад/-ээр орон нутгийн харьяалал харгалзахгүйгээр үнэ төлбөргүй /нийслэлд зориулалтын картаар/ зорчих бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хүний нийтийн тээврээр зорчсон төлбөрийг нийтийн тээврийн үйлчилгээ үзүүлсэн аймаг, нийслэлийн төсөвт жил бүр тусган, хэрэгжүүлнэ.

21.16.Энэ зүйлийн 21.12-т заасан харилцааг зохицуулах журмыг Засгийн газар баталж, шаардагдах хөрөнгийг нийтийн тээврийн үйлчилгээ үзүүлсэн аймаг, нийслэлийн жил бүрийн төсөвт тусган хэрэгжүүлнэ.

22 дугаар зүйл.Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хамт олонд түшиглэн хамруулан хөгжүүлэх

22.1.Хөгжлийн бэрхшээлтэй хүн хамт олонд түшиглэн хамруулан хөгжүүлэх үйлчилгээнд үнэ төлбөргүй хамрагдах эрхтэй.

22.2. Хамт олонд түшиглэн хамруулан хөгжүүлэх үйлчилгээг дараах чиглэлээр үзүүлнэ:

22.2.1.өвчин, эмгэг, гэмтэл, бэртлийн улмаас үүссэн үр дагаврыг арилган хэвийн байдалд оруулахад чиглэсэн эрүүл мэндийн;

22.2.2.хөгжлийн бэрхшээлтэй хүн бусдын адил боловсрол, мэргэжил эзэмшихийг дэмжих боловсролын;

22.2.3.хөгжлийн бэрхшээлтэй хүн гэр бүл, хамт олондоо эдийн засгийн хувьд хувь нэмрээ оруулахыг дэмжих хөдөлмөрийн;

22.2.4.хөгжлийн бэрхшээлтэй хүн, гэр бүл, хамт олны дунд бусдын адил үүрэг хариуцлага хүлээсэн, идэвхитэй, бие даасан гишүүн болохыг дэмжих нийгмийн;

22.2.5.хөгжлийн бэрхшээлтэй хүн нийгмийн харилцаанд оролцохыг дэмжих барилга байгууламж, авто зам, замын байгууламж, нийтийн тээвэр, мэдээллийн технологи, харилцаа холбоо, үйлчилгээний хүртээмжийн.

22.3.Хамт олонд түшиглэн хамруулан хөгжүүлэх үйлчилгээ үзүүлэх байгууллага нь тухайн хүний онцлог хэрэгцээнд тохирсон үйлчилгээний хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ.

22.4.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь хүүхдийг энэ хуулийн 27.2-д заасан дүгнэлтийн дагуу хамт олонд түшиглэн хамруулан хөгжүүлэх үйлчилгээнд хамруулна.

22.5.Энэ зүйлийн 22.1-д заасан үйлчилгээний хүртээмж, чанарыг нэмэгдүүлэхэд төрөөс дэмжлэг үзүүлнэ.

23 дугаар зүйл.Хамт олонд түшиглэн хамруулан хөгжүүлэх үйлчилгээ эрхлэх

23.1.Энэ хуулийн 22.1-д заасан үйлчилгээг өмчийн бүх хэлбэрийн байгууллага үзүүлнэ.

23.2.Хамт олонд түшиглэн хамруулан хөгжүүлэх үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх ашгийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг хуулийн этгээдээр гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх тохиолдолд зардлыг бүрэн болон хэсэгчлэн тухайн асуудлыг эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төсвөөс санхүүжүүлнэ.

23.3.Энэ хуулийн 22.1-д заасан үйлчилгээний удирдамжийг тухайн асуудлыг эрхэлсэн Засгийн газрын гишүүн, хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран батална.

23.4.Энэ зүйлийн 22.2-т заасан үйлчилгээний чиглэлийн хүрээнд үйлчилгээ үзүүлэх төрийн бус байгууллагыг магадлан итгэмжлэх журмыг тухайн асуудлыг эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

24 дүгээр зүйл. Хөгжлийн бэрхшээлтэй хүн бие даан амьдрах эрхийг хангах

24.1.18 ба түүнээс дээш насны хөгжлийн бэрхшээлтэй хүн бие даан амьдрах эрхтэй.

24.2. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хараат бус, бие даан амьдрах эрхийг хангахад чиглэсэн хүний эрхэд суурилсан нийгмийн цогц үйлчилгээг төрөөс дэмжинэ.

24.3.Хөгжлийн бэрхшээлтэй хүн бие даан амьдрахад дэмжлэг үзүүлэх үйлчилгээ дараах төрөлтэй байна:

- 24.3.1.хувийн туслах, хөтөчийн үйлчилгээ;
- 24.3.2.дэмжих бүлэг буюу харилцан суралцах үйлчилгээ;
- 24.3.3.сургалт мэдээлэл, зөвлөгөө өгөх үйлчилгээ;
- 24.3.4.бие даан амьдрахад бэлтгэх түр байрлуулах үйлчилгээ;
- 24.3.5.дохионы хэлний хэлмэрч, орчуулагчийн үйлчилгээ;
- 24.3.6.хөтөч нохойн үйлчилгээ

24.4.Энэ хуулийн 24.3.1-24.3.5-д заасан үйлчилгээ үзүүлэх байгууллагад тавигдах шаардлага, сонгон шалгаруулах журам, жишиг үнийг хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

24.5.Оюуны болон сэтгэцийн бэрхшээлтэй хүн бие даан амьдрах, дэмжлэгтэйгээр шийдвэр гаргахад үзүүлэх хувийн туслах, хөтөчийн үйлчилгээнд баримтлах ёс зүйн хэм хэмжээг хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

Тайлбар: “Дэмжлэгтэйгээр шийдвэр гаргах” гэж эрх зүйн чадамжгүй нь тогтоогдсон, оюуны болон сэтгэцийн бэрхшээлтэй хүн өөрт хамааралтай асуудлаар бие даан шийдвэр гаргахад нь дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг,

24.6. Энэ зүйлийн 24.3.1-т заасан хувийн туслах ажилтан бэлтгэх сургалтын болон олон нийтэд таниулах нөлөөллийн үйл ажиллагааны зардлыг Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд сангаас санхүүжүүлнэ.

24.7.Энэ зүйлийн 24.3.1-24.3.4-т заасан үйлчилгээнээс халамжийн үйлчилгээтэй холбогдох зардлыг Нийгмийн халамжийн сангаас санхүүжүүлнэ.

24.8.Энэ зүйлийн 24.3.5-д заасан үйлчилгээний төлбөрийг үйлчилгээ авсан байгууллага дохионы хэлний хэлмэрч, орчуулагчийн үйлчилгээ үзүүлсэн байгууллага, хувь хүнд төлнө.

24.9.Энэ зүйлийн 24.3.1-д заасан үйлчилгээ авах хүсэлт гаргасан хөгжлийн бэрхшээлтэй хүн, түүний эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч үйлчилгээний төлбөрийн 10 хүртэл хувийг хариуцна.

24.12.Энэ зүйлийн 24.3.6-д заасан үйлчилгээний журмыг хөгжлийн бэрхшээлтэй хүний, хөдөө аж ахуйн, хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

24.13.Хөтөч нохой сургахтай холбоотой хөрөнгийг хууль зүйн асуудал эрхэлсэн байгууллагын төсвөөс санхүүжүүлнэ.

24.14.Хөгжлийн бэрхшээлтэй хүн бие даан амьдрахад дэмжлэг үзүүлэх хуулийн этгээдийн сонгон шалгаруулалтыг хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага гүйцэтгэнэ.

25 дугаар зүйл.Хөгжлийн бэрхшээлтэй хүний жендэрийн эрх тэгш байдлыг хангах

25.1.Хөгжлийн бэрхшээлтэй хүний жендэрийн эрх тэгш байдлыг хангахад төрөөс дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

25.1.1.гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэл, гэмт хэрэгт өртөх эрсдэлтэй, өртсөн хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх эрүүл мэнд, хууль зүйн, сэтгэл зүйн болон бусад шаардлагатай үйлчилгээг түүний сэтгэл зүй, нас, бие, сэтгэхүйн онцлог хэрэгцээнд нийцүүлэн мэргэжлийн түвшинд хүртээмжтэй үзүүлэх;

25.1.2.гэрч, хохирогчийг хамгаалах байр нь хөгжлийн бэрхшээлтэй хүний онцлог хэрэгцээ, шаардлагад нийцсэн, хүртээмжтэй байх;

25.2.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах бодлого, үйл ажиллагааны хөтөлбөртөө хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн агуулгыг тусгаж, хэрэгжилтийг хангах, сургалт, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах асуудлыг Жендэрийн үндэсний хороо хариуцна.

26 дугаар зүйл.Онцгой байдлын үед авах арга хэмжээ

26.1.Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь хүний амь нас, эрүүл мэнд, аж амьдрал, нийтийн аюулгүй байдалд шууд аюул учруулсан буюу учруулахуйц байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюул, нийтийн эмх замбараагүй байдал, дайн бүхий байдал, цар тахал зэрэг онцгой байдлын үед хөгжлийн бэрхшээлтэй хүний амь нас, эрүүл мэндийг нь хамгаалах чиглэлээр дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

26.1.1.онцгой байдлын мэдээллийг хөгжлийн бэрхшээлийн онцлог хэрэгцээ, шаардлагад нь нийцүүлэн хүртээмжтэйгээр хүргэх;

26.1.2.хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хамруулсан гамшигын эрсдэлийг бууруулах төлөвлөгөө батлан хэрэгжүүлэх;

26.1.3. байгалийн гамшиг, цар тахлын үеийн хөл хорио, нийтийг хамарсан үймээн самуун, бослого тэмцэл, ажил хаялт, бүх нийтийн амралт, баяр ёслолын өдрүүдээс үл хамааран бүх цаг үе, нөхцөл байдалд хөгжлийн бэрхшээлтэй хүн энэ хуулийн 24.3.1, 24.3.5-д заасан үйлчилгээг тасалдуулахгүй авах боломжоор хангах.

26.2.Орон нутгийн анхан шатны захиргааны байгууллага өөрийн харьяаны нутаг дэвсгэрт оршин суугаа хөгжлийн бэрхшээлтэй хүний судалгааг гаргаж, гамшиг, онцгой байдлын авах арга хэмжээний төлөвлөгөөтэй байна.

26.3.Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай зардлыг онцгой байдлын асуул хариуцсан байгууллагын жил бүрийн төсөвт тусгана.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ЭСЭХИЙГ ТОГТООХ, БҮРТГЭХ

27 дугаар зүйл.Хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг тогтоох

27.1.Хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг дараах шалгуураар тогтооно:

27.1.1.эрхтэн тогтолцооны бүтцийн алдагдал, ангилал, хугацаа;

27.1.2.үйл ажиллагаа, хөгжлийн бэрхшээл, эрүүл мэндийн олон улсын ангилал.

27.2.Хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг дараах зөвлөл /цаашид “Зөвлөл” гэх/ тогтооно:

27.2.1.0-18 хүртэлх насны хүүхдийн хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын зөвлөл;

27.2.2.18 ба түүнээс дээш насны хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 37.7-д заасан эрүүл мэндийн магадлалын зөвлөл.

27.3.Энэ зүйлийн 27.2.1-д заасан зөвлөл нь хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дэргэд төв зөвлөл, аймаг, дүүрэгт орон тооны бус салбар зөвлөлтэй байна..

27.4.Энэ хуулийн 27.2.2-т заасан зөвлөл нь Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 43 дугаар зүйлд заасны дагуу ажиллана.

27.5.Энэ хуулийн 27.2.1-д заасан зөвлөл нь эрх, үүргийн хүрээнд шийдвэр гаргах ба энэ нь дүгнэлт, зөвлөмж хэлбэртэй байна.

27.6.Энэ хуулийн 27.3-т заасан Зөвлөлийн дүрмийг Засгийн газар батална.

27.7.Энэ хуулийн 27.3-т заасан **зөвлөл, салбар зөвлөл** хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээнд холбон зуучилна.

27.8. Энэ хуулийн 27.1.2-т заасан ангиллыг ашиглан хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хамруулах нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний чиглэлийг тогтоож, холбон зуучлах чиг үүрэг бүхий Мэргэжлийн зөвлөлийг Хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дэргэд, аймаг, дүүргийн Мэргэжлийн дэд зөвлөлийг Засаг даргын дэргэд ажиллуулна.

27.9.Энэ хуулийн 27.7, 27.8-д заасан холбон зуучлах үйлчилгээ үзүүлэх журмыг хөгжлийн бэрхшээлтэй хүний болон эрүүл мэнд, боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

27.10.Хүний хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг тодорхойлох аргачлал, өвчин эмгэгийн жагсаалтыг эрүүл мэндийн болон хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

27.11.Энэ хуулийн 27.2-т заасан зөвлөлөөс гаргасан дүгнэлт нь хөгжлийн бэрхшээлтэй хүний холбогдох хуульд заасан тэтгэвэр, тэтгэмж авах болон бусад хөнгөлөлт, тусламж, үйлчилгээнд хамрагдах үндсэн баримт бичиг болно.

27.12.Үйл ажиллагаа, хөгжлийн бэрхшээл, эрүүл мэндийн олон улсын ангиллыг үе шаттай нэвтрүүлэх төлөвлөгөөг эрүүл мэндийн, хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран баталж, хэрэгжүүлнэ.

28 дугаар зүйл.Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг бүртгэх, тоо мэдээллийг нэгтгэх

28.1.Энэ хуулийн 27.2-т заасан зөвлөл өөрийн дүгнэлтэд үндэслэн хөгжлийн бэрхшээлтэй хүнийг бүртгэж, үнэмлэх олгох ба мэдээллийг төрийн үйлчилгээний цахим системд тухай бүр оруулна.

28.2.Энэ зүйлийн 28.1-д заасан үнэмлэхийн загвар, түүнийг олгох журмыг хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

28.3.Энэ хуулийн 27.2-т заасан зөвлөл нь хөгжлийн бэрхшээлтэй болохыг тогтоосон хүний статистик мэдээллийг хуулиар тогтоосон хугацаанд хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

28.4.Хөгжлийн бэрхшээлтэй хүний мэдээллийг нэгтгэсэн “Мэдээллийн нэгдсэн сан”-г хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага бүрдүүлж, холбогдох байгууллагыг мэдээллээр хангана.

28.5.Энэ хуулийн 27.2-т заасан зөвлөлийн мэдээллээр энэ хуулийн 28.4-т заасан мэдээллийн нэгдсэн сангийн өөрчлөлт, хөдөлгөөнийг баяжуулалтыг хийх ба хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага статистик мэдээллийг нэгтгэн хуулиар тогтоосон хугацаанд статистикийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

28.6.Энэ хуулийн 28.5-д заасан "Мэдээллийн нэгдсэн сан"-г бүрдүүлэх статистик мэдээллийн үзүүлэлт, аргачлал, заавар, маягт, загварыг Статистикийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 4-т заасны дагуу хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

28.7.Хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжил, оролцоо, амьдралын чанарын сэдэвчилсэн судалгааг 2 жил тутамд гүйцэтгэж үр дүн, зөвлөмж, авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх саналыг Улсын Их Хуралд хүргүүлнэ.

ДОЛООДУГААР БҮЛЭГ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРХИЙГ ХАНГАХ ТОГТОЛЦОО

29 дүгээр зүйл.Улсын Их Хурлын бүрэн эрх

29.1.Монгол Улсын Их Хурал хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах, хангах талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

29.1.1.төрөөс баримтлах хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах, хангах бодлогыг тодорхойлох;

29.1.2.хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, хамгаалах хууль тогтоомжийн хүрээнд Засгийн газраас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээнд хяналт тавих, шаардлагатай төсвийг батлах;

29.1.3.энэ хуулийн 28.7-д заасан хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн хэрэгжилтийн тайланг Улсын Их Хурлын хаврын ээлжит чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, санал, зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар тогтоол гаргах;

29.1.4.хууль тогтоомжийг хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн мэдрэмжтэй боловсруулсан эсэхэд хяналт тавьж батлах;

29.1.6.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

30 дугаар зүйл.Монгол Улсын Засгийн газрын бүрэн эрх

30.1. Монгол Улсын Засгийн газар /цаашид "Засгийн газар" гэх/ хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, хамгаалах, дэмжих талаар Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 9 дүгээр зүйлд зааснаас гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

30.1.1. төрөөс хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, хамгаалах талаар баримтлах бодлогыг Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт эрхэд суурилсан хандлагад нийцүүлэн тусгаж хэрэгжүүлэх;

30.1.2.Төсвийн ерөнхийлөн захирагчийн жил бүрийн төсөвт хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангахад чиглэсэн бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүжилтийг хуваарилах, зарцуулалтад хяналт тавих;

30.1.3.Засгийн газрын гишүүдийн хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайланг жил бүрийн 2 дугаар сард багтаан хэлэлцэх;

30.1.4.хөгжлийн бэрхшээлийн салбар дахь хамтын ажиллагааны асуудлаар өөрийн бүрэн эрхийн хүрээнд бусад улсын Засгийн газар, олон улсын байгууллагатай гэрээ, хэлэлцээр хийх;

30.1.5.хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах хууль тогтоомжийг хэрэгжилтийг Улсын Их Хуралд тайлагнах;

30.1.6.хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн захиргааны болон үйлчилгээний удирдах, гүйцэтгэх, туслах албан тушаалын цалингийн хэмжээг тогтоох итгэлцүүр батлах;

30.1.7. хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

30.2.Засгийн газрын гишүүд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

30.2.1.санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн салбарын онцлогт нийцсэн, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангахад чиглэсэн зардлын ангиллыг **Төсвийн ерөнхийлөн захирагч тус бүрээр үүсгэн батлах;**

30.2.2.Төрийн албаны тухай хуулийн 53 дугаар зүйлд заасны дагуу байгууллагын стратеги төлөвлөгөөнд хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах асуудлыг тусгаж хэрэгжүүлэх;

30.2.3.хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах хууль, тогтоомжийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүр төсөвтөө тусгах, зарцуулалтыг олон нийтэд тайлагнах;

30.2.4.хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг дээдлэгч байгууллага, хүнийг шалгаруулан алдаршуулах ажлыг зохион байгуулах;

30.2.5.салбарын бодлого, хууль тогтоомжид хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжил, хамгааллыг сайжруулах, оролцоог хангах асуудлыг тусган хэрэгжүүлэх;

30.2.6. хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

31 дүгээр зүйл.Хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

31.1.Хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн харилцаанд тэгш оролцох эрхийг хангах чиглэлээр Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуульд зааснаас гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

31.1.1.хөгжлийн бэрхшээлтэй хүний тэгш эрхийг хангахад чиглэсэн салбар дундын бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг улсын хэмжээнд уялдуулан зохион байгуулж, биелэлтэд хяналт тавих, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах үндэсний хороонд болон хөгжийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд тайлагнах;

31.1.2.хөгжлийн бэрхшээлийн нөхцөл байдлыг судлах, үнэлэх, салбарын бодлого, хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох;

31.1.3.харьяа байгууллагын болон салбар дундын хүний нөөцийг тасралтгүй сургах, мэргэшүүлэх, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, үйл ажиллагааг нь уялдуулан зохицуулах;

31.1.4.хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, хамгаалах чиглэлээр бүх шатны Засаг дарга болон бусад салбарт мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх;

31.1.5.хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа хүн, өмчийн бүх хэлбэрийн байгууллагад хууль тогтоомжийн дагуу дэмжлэг үзүүлэх;

31.1.6.хөгжлийн бэрхшээлтэй хүний статистик мэдээллийг нэгтгэн гаргах, мэдээлэх;

31.1.7. хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн үйлчилгээний ажилтны нийгмийн баталгааг хангах бодлого хэрэгжүүлэх;

31.2.8.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

32дугаар зүйл. Хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бүрэн эрх

32.1.Хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуульд зааснаас гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

32.1.1.Хөгжлийн бэрхшээлтэй хүний талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах;

32.1.2.хуульд заасан болон холбогдох бусад тоо, статистик, мэдээллээр төрийн захиргааны төв байгууллагыг шуурхай хангах;

32.1.3.хөгжлийн бэрхшээлийн талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх сургалт, сурталчилгаа, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах;

32.1.4.өөрийн эрх хэмжээний хүрээнд хамаарахгүй асуудлаар шийдвэр гаргуулахаар эрх бүхий байгууллагад санал боловсруулж, уламжлах;

32.1.5.өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлж байгаа бодлого, арга хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн харилцаанд тэгш оролцох боломжийг бүрдүүлэх асуудлыг тусгаж, хэрэгжүүлэх;

32.1.6.хөгжлийн бэрхшээлтэй хүний мэдээллийн нэгдсэн сан үүсгэж баяжуулах, статистик, судалгаа шинжилгээний ажлыг бүх талаар дэмжих, мэдээллээр хангах;

32.1.7.Энэ хуульд заасан төрийн болон орон нутгийн захиргааны байгууллагын зарим чиг үүргийг хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх ашгийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж, зардлыг гэрээний үндсэн дээр санхүүжүүлэх, гэрээлэн гүйцэтгэж буй төрийн бус байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих;

32.1.8.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

33 дугаар зүйл. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах үндэсний хорооны бүрэн эрх

33.1.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах үндэсний хороо /цаашид “Үндэсний хороо” гэх/-г Монгол Улсын Ерөнхий сайдын дэргэд байгуулан ажиллуулна.

33.2.Үндэсний хорооны бүрэлдэхүүн, ажиллах журмыг Засгийн газар батална.

33.3.Үндэсний хороо жилд 2-оос доошгүй удаа хуралдана.

33.4.Үндэсний хороо нь төрийн захиргааны төв байгууллагад дэд хороо, аймаг, нийслэл, дүүрэгт салбар хороотой байх бөгөөд дэд хороог тухайн яамны Төрийн нарийн бичгийн дарга, салбар хороог тухайн шатны Засаг дарга тэргүүлнэ.

33.5.Үндэсний хорооны ажлын албаны үүргийг хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, салбар хорооны ажлын албаны үүргийг тухайн орон нутгийн нийгмийн бодлогын асуудал хариуцсан нэгж тус тус гүйцэтгэнэ.

33.6.Дэд хороог зарим төрийн захиргааны байгууллагын дэргэд байгуулж болох бөгөөд тухайн байгууллагын дарга тэргүүлнэ.

33.7.Үндэсний хороо нь хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах чиглэлээр дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

33.7.1.салбар дундын бодлого, үйл ажиллагааг улсын хэмжээнд уялдуулан зохицуулах, хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар хангах, хяналт тавих;

33.7.2.хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангахтай холбоотой асуудлаар хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төсвийн зарцуулалт болон олон улсын байгууллагаас гаргасан зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнтэй танилцах, зөвлөгөө өгөх;

33.7.3.дэд, салбар хорооны тайлан, мэдээллийг хэлэлцэж, дүгнэлт гаргах;

33.7.4. хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах чиглэлээр үр бүтээлтэй ажилласан хүн, хуулийн этгээдийг шагнал, урамшилд тодорхойлох;

33.7.5.хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангахтай холбогдсон хууль тогтоомж, бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтийн талаарх тайланг хэлэлцэж, Засгийн газарт танилцуулах;

33.7.6.хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах асуудлаар олон улсын байгууллага, гадаад улстай хийх хамтын ажиллагааг өргөжүүлэх;

33.7.7.хорооны үйл ажиллагааны төлөвлөгөөнд хүртээмжийг сайжруулах арга хэмжээг тусган хэрэгжүүлэх ба жил бүрийн нэгдүгээр улиралд багтаан хэрэгжилтийг дүгнэн хэлэлцэж, зөвлөмж гарган хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах дэд болон салбар хороонд хүргүүлэх;

33.7.8.дэд болон салбар хорооны үйл ажиллагааны нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулж, ажлаа эрчимжүүлэх зөвлөмж, албан даалгавар өгөх, хэрэгжилтийг хангуулах.

33.8.Үндэсний хороо ажлаа Засгийн газарт тайлагнана.

34 дүгээр зүйл.Бүх шатны Засаг даргын бүрэн эрх, хүлээх үүрэг

34.1.Бүх шатны Засаг дарга хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах талаар харьяалах нутаг дэвсгэртээ Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд зааснаас гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

34.1.1.хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, хамгаалах хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, төсөв хуваарилах, зарцуулах, хяналт тавьж, биелэлтийг хангуулах;

34.1.2.хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, хамгаалах, оролцоог дэмжих арга хэмжээний төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулж, хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих;

34.1.3.барилга байгууламж, авто зам, замын байгууламж, нийтийн тээвэр, мэдээллийн технологи, харилцаа холбоо, үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй хүнд саадгүй, хүртээмжтэй болгох арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

34.1.4.хөгжлийн бэрхшээлтэй хүнийг олон нийтэд түшиглэн хамруулан хөгжүүлэх үйлчилгээг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх;

34.1.5.хөгжлийн бэрхшээлтэй хүнд саадгүй, хүртээмжтэй орчин бүрдүүлэх, үйлчилгээ үзүүлэх талаар иргэн, хуулийн этгээдийн санал, санаачилгыг дэмжих;

34.1.6.энэ хуулийн 21.13-т заасны дагуу нийтийн тээврийн хэрэгслээр харьяалал харгалзахгүй үнэ төлбөргүй зорчуулах, нөхөн олговрыг санхүүжүүлэх журмыг хэрэгжүүлэх санхүүжилтийг жил бүрийн төсөвтөө тусган батлах;

34.1.7.хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах үйл ажиллагааны төлөвлөгөө, түүнд зарцуулах хөрөнгийг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн батлуулж, хэрэгжилтийг хангах;

34.1.8.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг сурталчлах, хэрэгжилтийг тухайн шатны Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд тайлагнах;

34.1.9.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

35 дугаар зүйл.Хуулийн этгээдийн нийтлэг эрх, үүрэг

35.1.Хуулийн этгээд нь хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах чиглэлээр дараах нийтлэг эрх, үүрэгтэй:

35.1.1.Хөдөлмөрийн тухай хуулийн 144.1-д заасан хөгжлийн бэрхшээлтэй хүний онцлог хэрэгцээ, шаардлагад нийцсэн ажиллах орчин, нөхцөл бүрдүүлэх, шаардлагатай тохиолдолд ажлын байрны дадлагажуулагчийн үйлчилгээг авах;

35.1.2.нийтийн зориулалттай үйлчилгээний болон бусад байгууллага хөгжлийн бэрхшээлтэй хүнд дараалал харгалзахгүй үйлчлэх;

35.1.3.хөгжлийн бэрхшээлтэй хүний амжилт, бүтээлийг олон нийтэд сурталчлан таниулах;

35.1.4.Хөдөлмөрийн тухай хуулийн 37.1.9-т заасан ажил үүргээ гүйцэтгэх явцад хөгжлийн бэрхшээлтэй болсон ажилтанд тусламж, дэмжлэг үзүүлэх;

35.1.5.хуулийн этгээд өөрчлөн зохион байгуулагдсан бол түүний эрх, үүргийг хүлээж авсан этгээд энэ хуулийн 34.1.4-т заасан эрх, үүргийг хэрэгжүүлэх;

35.1.6.хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй зүй бусаар харилцах, эрх, эрх чөлөөг нь зөрчих, ялгаварлах, бэлгийн болон бусад хэлбэрийн дарамт, хүчирхийллээс хамгаалах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг байгууллагын дотоод журамд тусгаж хэрэгжүүлэх;

35.1.7.бараа, ажил, үйлчилгээг хуулийн этгээдээр гэрээлэн гүйцэтгүүлэхээр сонгон шалгаруулалт зарласан тохиолдолд нийт ажиллагсдын 70 ба түүнээс дээш хувь нь хөгжлийн бэрхшээл ажиллаж байгаа хуулийн этгээдийг давуу эрхтэйгээр оролцуулах;

35.1.8.хууль тогтоомжид заасан бусад эрх, үүрэг.

36 дугаар зүйл.Төрийн бус байгууллагад тавигдах шаардлага, нийтлэг эрх, үүрэг

36.1.Төрийн чиг үүргийг гэрээний үндсэн дээр хэрэгжүүлэх хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага дараах шаардлагыг хангасан байна:

36.1.1.төрийн бус байгууллагын дүрмийн зорилгод нийцсэн үйл ажиллагаа явуулахад шаардлагатай эрх бүхий байгууллагаас олгосон зөвшөөрөл, магадлан итгэмжлэлтэй байх;

36.1.2.дүрмийн зорилгын дагуу сүүлийн гурваас доошгүй жил тогтвортой үйл ажиллагаа явуулсан, ажлын байртай, хоёроос доошгүй үндсэн ажилтантай байх.

36.2.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах чиглэлээр ажилладаг төрийн бус байгууллага дараах нийтлэг эрх, үүрэгтэй:

36.2.1.салбарын хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төрийн байгууллага, албан тушаалтны гаргасан шийдвэр, үйл ажиллагааны хэрэгжилтэд хөндлөнгийн хяналт тавих;

36.2.2.хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах чиглэлээр хороо, зөвлөлийн бүрэлдэхүүн, үйл ажиллагаанд оролцох;

36.2.3.хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудлаар салбарын хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, шийдвэрийн төсөлд санал өгөх, сургалт, сурталчилгааны ажлыг хамтран зохион байгуулах, гэрээгээр гүйцэтгэх;

36.2.4.энэ хуульд заасан төрийн зарим чиг үүргийг гэрээлэн гүйцэтгэх;

36.2.5.хууль тогтоомжид заасан бусад.

36.3.Хувийн туслах, бие даан амьдрах, хөгжлийн төв зэрэг хөгжлийн бэрхшээлтэй хүнд чиглэсэн үйлчилгээг гэрээлэн хүргэж байгаа төрийн бус байгууллагын үйл ажиллагааг захиалагч талаас хангалттай гэж үнэлсэн тохиолдолд гэрээний хугацааг сонгон шалгаруулалт зарлахгүйгээр 3 жил хүртэл сунгаж болно.

36.4.Энэ хуулийн 35.2.5-д заасан үйл ажиллагааг гэрээлэн гүйцэтгэсэн төрийн бус байгууллагын тогтвортой байдлыг хангах, хүний нөөцийг чадавхжуулахад зориулан гэрээт ажлын зардлын 30 хүртэл хувьтай тэнцэх хэмжээний зардлыг гэрээлсэн байгууллага урамшуулал болгож олгож болно.

37 дугаар зүйл. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн хэрэгжилтэд хяналт тавих

37.1.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих хяналтыг хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, төрийн болон орон нутгийн захиргааны байгууллага, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн улсын байцаагчаар дамжуулан хэрэгжүүлнэ.

37.2.Аймаг, нийслэл, сум, дүүрэг тус бүрт 1-ээс доошгүй хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн улсын байцаагчтай байна.

37.3.Хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга нь хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн улсын ерөнхий байцаагч байна.

37.4.Улсын ерөнхий байцаагчийн эрхийг хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн байцаагчийн эрхийг улсын ерөнхий байцаагч тус тус олгож, цуцална.

37.5.Улсын байцаагч нь хөгжлийн бэрхшээлийн салбарт 5-аас доошгүй жил ажилласан, дээд боловсрол эзэмшсэн байна.

37.6.Улсын байцаагч нь Төрийн хяналт шалгалтын тухай хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлж, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн зөрчлийг шалган шийдвэрлэнэ.

37.7.Улсын байцаагч нь хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн асуудлаар гаргасан санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг харьяа сум, дүүргийн холбогдох байгууллага, ажилтанд тавьж шийдвэрлүүлнэ.

37.8.Улсын байцаагчийг сонгон шалгаруулах, ажиллах журмыг хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

37.9.Байцаагч нь хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал хариуцсан Засгийн газрын гишүүний баталсан үнэмлэх, тэмдэг, мэдэгдэл, албан шаардлага, дүгнэлт, акт, торгуулийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

38 дугаар зүйл.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах салбарын ажилтны эрх, үүрэг, нийгмийн баталгаа

38.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн үйлчилгээний ажилтан Төрийн албаны тухай хуульд заасан нийтлэг баталгаанаас гадна энэ хуульд заасан эрх эдэлж, үүрэг хүлээж, нийгмийн баталгаагаар хангагдана.

38.2.Хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудлыг хариуцсан төрийн захиргааны болон үйлчилгээний ажилтан дараах эрхтэй:

38.2.1.эрүүл, аюулгүй, стандартын шаардлага хангасан орчин, нөхцөлд хууль тогтоомжид заасан чиг үүргийг хэрэгжүүлж, гүйцэтгэсэн ажил үүрэгтээ тохирсон цалин хөлс авах;

38.2.2.судалгаа шинжилгээний ажил хийх;

38.2.3.эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт жил бүр хамрагдах;

38.2.4.байгууллагын хөгжлийн бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө, дүрэм, журам боловсруулах, хэрэгжүүлэх, төсөв, хөрөнгө оруулалтын төлөвлөлт хийх болон шийдвэр гаргахад санал өгөх;

38.2.5.хүмүүнлэгийн болон сайн дурын үйл ажиллагааг санаачлах, оролцох;

38.2.6.хууль тогтоомжид заасны дагуу тусламж авах, хөнгөлөлт эдлэх,нийгмийн баталгаагаар хангагдах;

38.2.7. мэргэжлийн хөгжлийн орчин, нөхцөлөөр хангагдах;

38.2.8.хуульд заасан бусад эрх.

38.3. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн үйлчилгээний ажилтан дараах үүрэгтэй:

38.3.1.хөгжлийн бэрхшээлтэй хүний онцлог хэрэгцээнд нийцсэн, алдагдсан чадварыг боломжит дээд хэмжээнд нь хүртэл нөхөн сэргээхэд чиглэсэн үйлчилгээг чанартай хүргэх;

38.3.2. хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хүндэтгэх, бие даасан байр суурь, үзэл бодол, онцлог байдлыг нь хүлээн зөвшөөрч зөв хандлагаар чиглүүлж, хөгжүүлэх;

38.3.3.хувь хүний нууцыг хадгалах, хамгаалах, үйлчлүүлэгчийг ялгаварлан гадуурхсан аливаа үйлдэл гаргахгүй байх;

38.3.4.төрийн албан хаагчийн ёс зүйг чандлан сахиж, нэр төрийг эрхэмлэх;

38.3.5.ажлын байранд болон бусад хэлбэрээр мэргэжлээ дээшлүүлэн, өөрийгөө хөгжүүлж, бусадтай хамтран ажиллах, бусдыг хүндэтгэх;

38.3.6.хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг зөрчих, байгууллагын хэвийн үйл ажиллагааг алдагдуулахад чиглэсэн арга хэмжээ төлөвлөх, зохион байгуулах, тэдгээрт оролцох, удирдлага, ажилтан хууль тогтоомжоор хүлээсэн албан үүргээ гүйцэтгэхэд саад учруулах үйлдэл гаргахгүй байх;

38.3.7.байгууллагын үйл ажиллагаанд оролцох, байгууллагын өөрийн удирдлага, ажилтан, үйлчлүүлэгч, тэдний эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, төлөөллийн байгууллагатай хамтран ажиллах, дэмжин туслах;

38.3.8.улс төрөөс ангид байж, хуулиар зөвшөөрснөөс бусад улс төрийн аливаа үйл ажиллагаанд оролцохгүй байх;

38.3.9.холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, заавар, аргачлалыг чанд сахин мөрдөх;

38.3.10.ажлын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнд үндэслэн мэргэжлийн хөгжлийн хэрэгцээг тодорхойлж, төлөвлөх, хэрэгжүүлэх;

38.3.11.хуульд заасан бусад.

38.4. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн үйлчилгээний ажилтан дараах нийгмийн баталгаагаар хангагдана:

38.4.1. тухайн нутаг дэвсгэрийн онцлог, төвөөс алслагдсан байдлыг харгалзан удирдлага, ажилтанд нэмэгдэл цалин, урамшуулал, бусад дэмжлэг олгох;

38.4.2. хөгжлийн бэрхшээлтэй хүнд үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий аймаг, сум, баг, тосгон дахь төрийн болон орон нутгийн өмчийн байгууллагын удирдлага, ажилтанд эхний тав дахь жилд болон дараагийн гурав дахь жил тутамд нэг удаа зургаан сарын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийг улсын төсвөөс олгох;

38.4.3. хөгжлийн бэрхшээлтэй хүнд үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий төрийн болон орон нутгийн өмчийн байгууллагын удирдлага, ажилтан өндөр насны тэтгэвэр тогтоолгоход Төрийн албаны тухай хуульд заасны дагуу нэг удаагийн буцалтгүй тусламж олгох;

38.5. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн үйлчилгээний байгууллагын удирдлага, ажилтны амьдрах нөхцөлийг сайжруулах, орон сууцжуулахад төрөөс дэмжлэг үзүүлнэ.

38.6. Төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн болон хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн үнэлгээнд үндэслэн цалин хөлсийг нэмэгдүүлж болно.

38.7. Төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн болон хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн үнэлгээ хийх журмыг Засгийн газар батална.

38.8. Хууль тогтоомжид зааснаас бусад чиг үүргийг хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн үйлчилгээний ажилтнаар гүйцэтгүүлэхийг хориглоно

38.9. хуульд заасан бусад баталгаа

38.10. Энэ хуулийн 37.1-т заасан нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн баталж, шаардлагатай хөрөнгийг тухайн жилийн төсөвтөө тусгана.

НАЙМДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

39 дүгээр зүйл. Гомдол, нэхэмжлэл гаргах

39.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүн, байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, насанд хүрэгчийг асарч буй хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигч хуульд заасан эрх нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар холбогдох хууль тогтоомжид заасны дагуу төрийн байгууллагад гомдол, хүсэлт, шүүхэд нэхэмжлэл, холбогдох албан тушаалтанд хүсэлт, шаардлагыг өөрөө, эсхүл хууль ёсны төлөөлөөрөө дамжуулан гаргах эрхтэй.

39.2. Өмчийн бүх хэлбэрийн байгууллага хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй, эсхүл тухайн байгууллагын гаргасан тушаал, шийдвэрийн улмаас хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх зөрчигдсөн гэж үзвэл тэднийг эрх ашгийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг иргэний нийгмийн байгууллага шүүхэд гомдол гаргах эрхтэй.

39.3. Энэ хуулийн 39.2-т заасан иргэний нийгмийн байгууллага шүүхээр тогтоогдсон бодит хохирлын 10 хувийг тухайн байгууллагын гаргасан зардлыг санхүүжүүлэхэд зориулж, шүүхийн шийдвэрээр нэхэмжлэлийн шаардлага дээр нэмж төлүүлнэ.

40 дүгээр зүйл.Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

40.1.Энэ хуулийг зөрчсөн төрийн албан хаагчийн үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

40.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

40.3.Энэ хуулийн 39.1, 39.2-т заасан хариуцлага хүлээсэн этгээдийг энэ хуулийн 7.1.1-д заасан агуулга бүхий, 40-өөс доошгүй цагийн албадан сургалтад өөрийнх нь зардлаар хамруулна.

40.4.Энэ хуулийн 39.3-т заасан сургалтыг энэ хуулийн 7.3-т заасан журмын шаардлага ханган сургалт зохион байгуулах эрх авсан байгууллага хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн байгууллагатай хамтран зохион байгуулна.

40.5.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээд, албан тушаалтаны буруутай үйлдэл, эс үйлдэхүйн улмаас хөгжлийн бэрхшээлтэй хүнд гэм хор, хохирол, хор уршиг учирсан бол буруутай этгээдээр холбогдох хуульд заасны дагуу хохирлыг нөхөн төлүүлнэ.

40.6. Иргэн, хуулийн этгээдийн мэргэжлийн болон ёс зүйн алдаатай аливаа үйлдэл, эс үйлдэхүй нь хүнийг хөгжлийн бэрхшээлтэй болгосон, эсхүл хөгжлийн бэрхшээлийг буруу тогтоосон, сэтгэлзүйн дарамтад оруулсан нь тогдоогдсон бол эрүүл мэндийг нөхөн сэргээхтэй холбоотой үүссэн зардал болон сэтгэл санааны хохирлыг барагдуулна.

41 дүгээр зүйл.Хуулийг даган мөрдөх

41.1.Энэ хуулийг 202... оны дүгээр сарын ...-ний өдрөөс эхлэн даган мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ